



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

280.	Малын индексжүүлсэн даатгалын тухай	1120
281.	Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1133
282.	Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1133
283.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1134
284.	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1134
285.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1135
286.	Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	1135
287.	Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай	1136
288.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1136
289.	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1136
290.	Харицаа, холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1137
291.	Газрын тосны тухай /Шинэчилсэн найруулга/	1138
292.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1175
293.	Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1175
294.	Газрын тосны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1176
295.	Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай	1176



296.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1177
297.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1177
298.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1178
299.	Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1178
300.	Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1179
301.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1180
302.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1180
303.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1181
304.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1189
305.	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	1190
306.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1190
307.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1191
308.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1191
309.	Шилэн дансны тухай	1192
310.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1202
311.	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1202



312.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1203
313.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1203
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>			
314.	Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 45	1204
315.	Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	Дугаар 46	1205
316.	Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 47	1206
317.	Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 48	1207
318.	Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 49	1209
319.	Байнгын хорооны даргыг чөлөөлөх тухай	Дугаар 50	1209
320.	Байнгын хорооны даргыг сонгох тухай	Дугаар 51	1210
321.	Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 52	1210
322.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай	Дугаар 53	1211
323.	Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн тухай	Дугаар 54	1240



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 06 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, төрөөс тавих хяналт, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, малын давхар даатгал, даатгагч болон даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомж

2.1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, Даатгалын тухай<sup>3</sup>, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай<sup>4</sup>, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай<sup>5</sup>, Компанийн тухай<sup>6</sup>, Статистикийн тухай хууль<sup>7</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Даатгалтай холбогдсон нийтлэг харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.2.Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулийн 3.1-д зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2005 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup>Компанийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup>Статистикийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1997 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



3.3.Малын индексжүүлсэн даатгалд малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээд даатгуулж болно.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа” гэж даатгуулагчид учирсан бодит хохирлоор бус, даатгалын хамрах хугацаанд сумын хэмжээнд гарсан том малын хорогдлын хувь босго үзүүлэлтээс давсан тохиолдолд босго үзүүлэлтээс давсан хувь болон даатгалын үнэлгээнээс тооцож, даатгуулагчид нөхөн төлбөр олгох даатгалын үйл ажиллагаа буюу Даатгалын тухай хуулийн 4.3-т заасан үйл ажиллагааг;

4.1.2.“сумын малын хорогдол” гэж жилийн эцсийн болон хагас жилийн мал тооллогын албан ёсны дүн мэдээнд үндэслэн тооцоолсон том малын хорогдлын тоог;

4.1.3.“малын хорогдлын босго үзүүлэлт /цаашид “босго үзүүлэлт” гэх/ гэж Засгийн газраас сум бүрт малын төрлөөр ялгавартай тогтоосон том малын хорогдлын хувийг;

4.1.4.“том малын хорогдол” гэж тухайн жилийн оны эхнээс хагас жилийн мал тооллого хүртэл хугацаанд зүй бусаар хорогдсон төлөөс бусад насны малын тоог;

4.1.5.“малын индексжүүлсэн даатгалын тохиолдол” /цаашид “даатгалын тохиолдол” гэх/ гэж энэ хуулийн 4.1.6-д заасан даатгалын хамрах хугацаанд тухайн сумын малын хорогдол босго үзүүлэлтээс давсан нөхцөл байдал үүсэхийг;

4.1.6.“даатгалын хамрах хугацаа” гэж тухайн оны жилийн эцсийн мал тооллогоос дараа оны хагас жилийн мал тооллого хүртэл хугацааг;

4.1.7.“малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр” /цаашид “нөхөн төлбөр” гэх/ гэж даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгуулсан малын төрөл тус бүрт даатгагчаас даатгуулагчид даатгалын гэрээний дагуу олгох мөнгөн хөрөнгийг;

4.1.8.“малын индексжүүлсэн даатгалын гэрээ” /цаашид “даатгалын гэрээ” гэх/ гэж даатгагч даатгалын тохиолдол бий болоход



энэ хууль болон даатгалын гэрээнд заасны дагуу нөхөн төлбөр төлөх, даатгуулагч даатгалын хураамж төлөхөөр харилцан тохиролцсон хэлцлийг;

4.1.9.“малын давхар даатгалын компани /цаашид “давхар даатгалын компани” гэх/ гэж энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулах, тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

4.1.10.“Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан” гэж энэ хуулийн 8.1.2-т заасан түвшинд гарсан давхар даатгалын нөхөн төлбөр төлөх зориулалттай санг;

4.1.11.“Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан” гэж энэ хуулийн 8.1.3-т заасан түвшинд гарсан нөхөн төлбөр төлөх зориулалттай санг;

4.1.12.“Алдагдлаас хамгаалах сан” гэж даатгалын хохирлыг нөхөн төлөхөд зориулсан, энэ хуулийн 4.1.10, 4.1.11-д заасан сангийн хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд ашиглах зориулалт бүхий санг;

4.1.13.“Хамтын эрсдэлийн сан” гэж даатгуулагчид учирсан хохирлыг нөхөн төлөх үүргийг хамтран хариуцахаар хэд хэдэн даатгагч хамтарч энэ хуулийн дагуу байгуулсан санг;

4.1.14.“малын давхар даатгалын гэрээ” /цаашид “давхар даатгалын гэрээ” гэх/ гэж даатгагч даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ давхар даатгалын компанид хэсэгчлэн шилжүүлэхээр харилцан тохиролцсон хэлцлийг;

4.1.15.“олон улсын давхар даатгалын гэрээ” гэж давхар даатгалын компани даатгагчийн өмнө хүлээсэн үүргээ багцлан гадаад улсын давхар даатгалын компанид бүрэн, эсхүл хэсэгчлэн шилжүүлэхээр харилцан тохиролцсон хэлцлийг.

## **5 дугаар зүйл.Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд баримтлах зарчим**

5.1.Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.сайн дурын үндсэн дээр даатгалд хамрагдах;

5.1.2.малыг тухайн мал тоологдсон сумын нутаг дэвсгэрт даатгуулах;



5.1.3. малыг төрлөөр нь даатгуулах;  
5.1.4. малын хорогдлын хувийг сумын түвшинд тодорхойлох;

5.1.5. нөхөн төлбөрийг тооцоходоо индекст суурилах.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ, НӨХӨН ТӨЛБӨР**

#### **6 дугаар зүйл. Сумын малын хорогдлыг тогтоох, мэдээлэх**

6.1. Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухайн оны хагас жилийн мал тооллогын дүнг үндэслэн сумын малын хорогдлын тоог гаргана.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан тооллогыг тухайн жилийн 6 дугаар сарын эхний хагаст багтаан түүвэр судалгааны аргаар зохион байгуулна.

6.3. Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 6.1-д заасны дагуу тогтоосон малын хорогдлын тоог өнгөрсөн жилийн эцэст тоологдсон малын тоонд харьцуулан сумын малын хорогдлын хувийг малын төрөл тус бүрээр гаргаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

6.4. Бүх шатны Засаг дарга Статистикийн тухай хуульд заасан статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрхээс гадна энэ хуулийн 6.3-т заасан мэдээллийг даатгуулагчид шуурхай хүргэх арга хэмжээг авна.

#### **7 дугаар зүйл. Босго үзүүлэлтийг тогтоох**

7.1. Даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор босго үзүүлэлтийг дараах байдлаар Засгийн газар сум бүрээр тогтооно:

7.1.1. даатгуулагчийн эрсдэл хүлээх буюу нэгдүгээр босго үзүүлэлт;

7.1.2. даатгагчийн эрсдэл хүлээх буюу хоёрдугаар босго үзүүлэлт.

7.2. Нэгдүгээр босго үзүүлэлт зургаан хувь, хоёрдугаар босго үзүүлэлт 30 хувь байна.

7.3. Засгийн газар доор дурдсан нөхцөлийг харгалзан гурван жил тутам босго үзүүлэлтийг шинэчлэн тогтооно:



- 7.3.1.тухайн сумын малын хорогдол;
- 7.3.2.даатгуулагчийн тоо;
- 7.3.3.хураамжийн орлогын хэмжээ;
- 7.3.4.нөхөн төлбөр олголт.

7.4.Засгийн газар босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоохдоо нэгдүгээр босго үзүүлэлтийг нэг хувиар, хоёрдугаар босго үзүүлэлтийг тав хүртэл хувиар нэмэгдүүлж, эсхүл бууруулж болно.

### **8 дугаар зүйл.Даатгалын эрсдэлийн түвшин**

8.1.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон босго үзүүлэлтийг үндэслэн эрсдэлийн түвшинг дараах байдлаар ангилна:

8.1.1.нэгдүгээр босго үзүүлэлт хүртэл хувиар мал хорогдсон бол эрсдэлийн бага түвшин;

8.1.2.нэгдүгээр босго үзүүлэлтээс хоёрдугаар босго үзүүлэлт хүртэл хувиар мал хорогдсон бол эрсдэлийн дунд түвшин;

8.1.3.хоёрдугаар босго үзүүлэлтээс дээш хувиар мал хорогдсон бол эрсдэлийн дээд түвшин.

### **9 дүгээр зүйл.Даатгалын хураамж**

9.1.Засгийн газраас тогтоосон босго үзүүлэлттэй уялдуулан хураамжийг доор дурдсан этгээд дараах байдлаар хариуцна:

9.1.1.хоёрдугаар босго үзүүлэлт хүртэлх эрсдэлийн дунд түвшин дэх даатгалын хураамжийг даатгуулагч;

9.1.2.хоёрдугаар босго үзүүлэлтээс давсан эрсдэлийн дээд түвшин дэх давхар даатгалын хураамжийг Засгийн газар.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан хураамжтай холбогдох журмыг даатгагчдын саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

9.3.Энэ хуулийн 9.1.1-д заасан даатгалын хураамжийн хэмжээг энэ хуулийн 9.2-т заасан журмын дагуу даатгагчид хамтран тогтооно.





### **10 дугаар зүйл. Даатгалын тохиолдол**

10.1. Энэ хуулийн 6.3-т заасны дагуу нийтэд мэдээлсэн сумын малын хорогдол Засгийн газраас тогтоосон нэгдүгээр босго үзүүлэлтээс давсан бол даатгалын тохиолдол бий болсон гэж үзнэ.

10.2. Гоц халдварт өвчний улмаас устгасан малын хорогдол даатгалын тохиолдолд үл хамаарна.

### **11 дүгээр зүйл. Даатгалын эрсдэлийн хуваарилалт**

11.1. Даатгалын эрсдэлийг доор дурдсан этгээд дараах байдлаар хариуцна:

11.1.1. Энэ хуулийн 8.1.1-д заасан түвшинд гарсан эрсдэлийг малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр;

11.1.2. Энэ хуулийн 8.1.2-т заасан түвшинд гарсан эрсдэлийг даатгагч хамтын эрсдэлийн санд оруулсан хөрөнгөөр;

11.1.3. Энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т зааснаас бусад эрсдэлийг давхар даатгалын компани энэ хуулийн 27.1-д заасан сангийн хөрөнгөөр.

### **12 дугаар зүйл. Нөхөн төлбөр**

12.1. Даатгагч энэ хуулийн 6.3-т заасан мэдээлэлд үндэслэн даатгалын гэрээнд заасны дагуу даатгуулагчид нөхөн төлбөрийг малын төрөл тус бүрээр тооцон банкаар дамжуулан олгоно.

12.2. Даатгагч нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгохыг хориглоно.

12.3. Энэ хуулийн 6.3-т заасны дагуу мэдээлсэн сумын малын хорогдлын хувь босго үзүүлэлтэд хүрээгүй тохиолдолд даатгуулагчид нөхөн төлбөр олгохгүй.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **13 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх**

13.1. Даатгалын компани /цаашид “даатгагч” гэх/ дараах шаардлагыг хангасан тохиолдолд малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд оролцоно:



13.1.1.Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд малын индексжүүлсэн даатгалын төрлийг зөвшөөрсөн байх;

13.1.2.энэ хуулийн 18.1-д заасан компанитай давхар даатгалын гэрээ байгуулсан байх.

13.2.Энэ хуулийн 13.1.2-т заасны дагуу давхар даатгалын гэрээ байгуулаагүй даатгагч нь малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээдтэй даатгалын гэрээ байгуулахыг хориглоно.

#### **14 дүгээр зүйл.Даатгалын гэрээ**

14.1.Даатгалын гэрээнд Иргэний хууль болон Даатгалын тухай хуульд зааснаас гадна дараах нөхцөлийг тусгасан байна:

14.1.1.даатгуулсан малын төрөл, түүний хураамжийн хэмжээ;

14.1.2.даатгуулагчийн даатгалд хамруулсан малын үнэлгээ;

14.1.3.нөхөн төлбөр олгох нэгдүгээр босго үзүүлэлт.

#### **15 дугаар зүйл.Даатгуулагчийн эрх, үүрэг**

15.1.Даатгуулагч дараах эрх эдэлнэ:

15.1.1.малын төрлөө сонгон даатгуулах;

15.1.2.малын төрөл тус бүрт даатгалын үнэлгээг сонгох, даатгалын тохиолдол үүсэхэд нөхөн төлбөрөө тогтоосон хугацаанд бүрэн авах;

15.1.3.даатгалын хураамжийг даатгалын гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх.

15.2.Даатгуулагч даатгуулах малын төрөл, тоогоо үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.

#### **16 дугаар зүйл.Даатгагчийн эрх, үүрэг**

16.1.Даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагч энэ хуулийн 18.1-д заасан компанитай давхар даатгалын гэрээ байгуулснаар даатгалын үйл ажиллагаанд оролцох эрхтэй болно.

16.2.Даатгагч дараах үүрэг хүлээнэ:



16.2.1.даатгалын үйл ажиллагаанд зөвхөн энэ хуулийн 21.2.6-д заасны дагуу баталсан даатгалын гэрээний загварыг хэрэглэх;

16.2.2.давхар даатгалын хураамжийг хугацаанд нь бүрэн төлөх.

### **17 дугаар зүйл.Засгийн газрын эрх, үүрэг**

17.1.Засгийн газар давхар даатгалын компанийн үүсгэн байгуулагч байна.

17.2.Засгийн газар давхар даатгалын компанийг үүсгэн байгуулахад төрөөс оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө болон Алдагдлаас хамгаалах санг бүрдүүлнэ.

17.3.Засгийн газар энэ хуулийн 9.1.2-т заасан хураамжийг жил бүрийн улсын төсөвт тусгаж, давхар даатгалын компаниар дамжуулан олон улсын давхар даатгалд даатгуулна.

17.4.Засгийн газар энэ хуулийн 6.2-т заасны дагуу статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулах хагас жилийн мал тооллогын зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлуулна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **18 дугаар зүйл.Давхар даатгалын компанийн эрх зүйн байдал**

18.1.Давхар даатгалын компани Даатгалын тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл авсан малын давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх, тусгайлсан чиг үүрэг бүхий ашгийн төлөө, төрийн болон хувийн өмчийн оролцоотой хувьцаат компани байна.

18.2.Давхар даатгалын компанийн удирдлага үйл ажиллагаандаа бие даасан, олон нийтэд ил тод байх компанийн засаглалын үндсэн зарчмыг баримтална.

18.3.Энэ хуулийн 18.1-д заасан компанийн төрийн өмчийн төлөөллийг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлнэ.

18.4.Компанийн тухай хуульд заасны дагуу давхар даатгалын компани нь хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагатай байна.



18.5.Давхар даатгалын компанитай холбогдох энэ хуульд зааснаас бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.

### **19 дүгээр зүйл.Давхар даатгалын компанийн өөрийн хөрөнгө**

19.1.Давхар даатгалын компанийн өөрийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

19.1.1.давхар даатгалын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө анх удаа бүрдүүлэхэд улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

19.1.2.хувьцаа худалдан борлуулсны орлого;

19.1.3.хуримтлагдсан ашиг;

19.1.4.хуульд заасан бусад эх үүсвэр.

19.2.Давхар даатгалын компанийн өөрийн хөрөнгийн доод хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.

### **20 дугаар зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал**

20.1.Компанийн тухай хуульд заасны дагуу давхар даатгалын компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

20.2.Давхар даатгалын компанийн дүрэмд заасан зарласан хувьцааг гаргах хүртэл санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

### **21 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл**

21.1.Давхар даатгалын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд санхүүгийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, даатгуулагч болон даатгагчийн төлөөллийг оруулна.

21.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.2.1.даатгалын бүтээгдэхүүн актуар тооцоолол болон бусад техник судалгааг хийж, зөвлөмж гаргах, аргачлалаар хангах, шаардлагатай бол дүгнэлт гаргах;

21.2.2.давхар даатгалын компанийн стратеги болон үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;



21.2.3.энэ хуулийн 27.1-д заасан сангийн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах шийдвэр гаргах;

21.2.4.Хамтын эрсдэлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр хэлэлцэж, сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

21.2.5.давхар даатгалын хураамжийн орлого, зарлагын талаар гүйцэтгэх захирлын тайланг хэлэлцэх;

21.2.6.даатгалын гэрээний загварыг батлах;

21.2.7.олон улсын давхар даатгагчид давхар даатгуулах эсэх асуудлаар шийдвэр гаргах;

21.2.8.шаардлагатай гэж үзвэл малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдуулан даатгалын компанид хяналт шалгалт хийлгэх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд тавих;

21.2.9.хууль болон давхар даатгалын компанийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

21.3.Давхар даатгалын компанийн дүрэмд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захиралд тавигдах шаардлагыг тусгана.

## **22 дугаар зүйл.Гүйцэтгэх захирал**

22.1.Гүйцэтгэх захирал давхар даатгалын компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан бүрэн эрхийн хүрээнд төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу давхар даатгалын компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

22.2.Төлөөлөн удирдах зөвлөл нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, гүйцэтгэх захирлыг томилно.

22.3.Гүйцэтгэх захирал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.3.1.Малын индексжүүлсэн даатгалын талаарх нэгдсэн бүртгэл хөтлөх, тайлагнах;

22.3.2.улирлын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, бусад мэдээллийг даатгагчаас авч, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, энэ талаарх мэдээллийг төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;



22.3.3.Хамтын эрсдэлийн санг удирдах;  
22.3.4.давхар даатгалын компанийн дүрэмд заасан бусад  
бүрэн эрх.

### **23 дугаар зүйл.Дотоод мэдээллийн нууцыг хадгалах**

23.1.Хуульд өөрөөр заагаагүй бол дараах этгээд албан үүргийнхээ дагуу олж мэдсэн, давхар даатгалын компанийн үйл ажиллагааны талаарх нууцын зэрэглэлтэй баримт, мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэгтэй:

23.1.1.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;  
23.1.2.энэ хуулийн 18.1-д заасан компанийн болон даатгалын компанийн ажилтан;

23.1.3.даатгалын төлөөлөгч, зуучлагч зэрэг гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа этгээд.

23.2.Давхар даатгалын компанитай байгуулсан гэрээ дуусгавар болсноос хойш таван жил энэ хуулийн 23.1-д заасан баримт, мэдээ, мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

### **24 дүгээр зүйл.Санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайлан**

24.1.Давхар даатгалын компанийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль<sup>8</sup>-д заасны дагуу гаргаж, санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд аудит хийлгэнэ.

24.2.Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг давхар даатгалын компанийн гүйцэтгэх захирал хариуцна.

24.3.Давхар даатгалын компани энэ хуулийн 24.1-д заасан тухайн жилийн тайлан, аудитын дүгнэлтийг дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, тайланг баталгаажуулна.

24.4.Давхар даатгалын компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хоёр жил тутамд төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгосон, олон улсын нэр хүнд бүхий байгууллагаар аудит хийлгэж,

<sup>8</sup>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



дүгнэлтийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Санхүүгийн зохицуулах хорооны даргад хүргүүлнэ.

24.5.Давхар даатгалын компанийн жилийн тайлан, тайлан тэнцэл, орлого зарлагын тайлан болон аудитын дүгнэлтийг нийтэд мэдээлнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН САН**

### **25 дугаар зүйл.Малын индексжүүлсэн даатгалын сангийн төрөл**

25.1.Малын индексжүүлсэн даатгалын сан дараах төрөлтэй байна:

- 25.1.1.даатгагчдын Хамтын эрсдэлийн сан;
- 25.1.2.давхар даатгалын компанийн сан.

### **26 дугаар зүйл.Хамтын эрсдэлийн сан**

26.1.Хамтын эрсдэлийн сан нь давхар даатгалын компанийн дэргэд тусдаа бүртгэлтэй, бие даасан данстай байна.

26.2.Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.

26.3.Хамтын эрсдэлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жил бүр тогтооно.

26.4.Даатгалын компани татан буугдахад Хамтын эрсдэлийн сангийн өөрт ногдох хэсгийг зөвхөн энэ хуулийн 11.1.2-т заасны дагуу зарцуулах бөгөөд энэ хэмжээгээр даатгагчийн хуваарилагдах хөрөнгөд тооцогдохгүй.

### **27 дугаар зүйл.Давхар даатгалын компанийн сан**

27.1.Давхар даатгалын компани дараах бие даасан сантай байна:

- 27.1.1.энэ хуулийн 4.1.10-т заасан эрсдэлээс хамгаалах сан;
- 27.1.2.энэ хуулийн 4.1.11-д заасан эрсдэлээс хамгаалах сан;
- 27.1.3.Алдагдлаас хамгаалах сан.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулахтай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.



## ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД

### **28 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих**

28.1. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Санхүүгийн зохицуулах хороо болон бүх шатны Засаг дарга, давхар даатгалын компанийн удирдлага холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

### **29 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

29.1. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд шүүгч, эсхүл холбогдох улсын байцаагч доор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

29.1.1. давхар даатгалын гэрээ байгуулахгүйгээр малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа явуулсан этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

29.1.2. нөхөн төлбөр бүрэн олгоогүй, эсхүл олгохоос үндэслэлгүйгээр татгалзсан этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

29.1.3. зохих журмыг зөрчин Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулсан этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

29.1.4. зохих журмыг зөрчин давхар даатгалын компанийн сангийн хөрөнгийг зарцуулсан этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

29.2. Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчид Статистикийн тухай болон Төрийн албаны тухай хууль<sup>9</sup>-д заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

29.3. Энэ хуулийг хоёр ба түүнээс дээш удаа зөрчсөн бол малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно.

<sup>9</sup>Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.





29.4.Энэ хуулийг зөрчсөнөөс учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр Иргэний хуульд заасны дагуу нөхөн төлүүлнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 06 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг:**

“3.5.Малын индексжүүлсэн даатгалын харилцааг хуулиар зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “3.5” дахь хэсгийн дугаарыг “3.6” гэж, “энэ хуулийн 3.1-3.4-т зааснаас бусад” гэснийг “энэ хуулийн 3.1-3.5-д зааснаас бусад” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 06 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

**СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “в” дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“в/мал, тэжээвэр амьтдын тооллогыг жил тутам, малын хагас жилийн тооллогыг түүвэр судалгааны аргаар хуульд заасан хугацаанд;”



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 06 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хадгаламжийн даатгалын корпорацийн” гэсний дараа “болон Малын индексжүүлсэн даатгалын” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 06 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ  
ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт**

“3.1.8.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан даатгалын үйл ажиллагаа;”

**2/6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт**

“6.2.7.малын даатгалын үйл ажиллагааны чиглэлээр Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан.”



**2 дугаар зүйл.** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “3.1.8” дахь заалтын дугаарыг “3.1.9” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 06 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН  
ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “Монгол Улсын Ерөнхийлөгч” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 06 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ  
ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ  
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 06 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Дипломат албаны тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.2 дахь хэсэг нэмсүгэй:

“5.2.Энэ хуулийн 5.1.14-т заасан төрийн дипломат ёслолыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан Төрийн ёслолын журмаар зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН  
ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “13” гэсний дараа “, 14, 15” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалтын “13” гэсний дараа “, 14, 15” гэж нэмсүгэй.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Харилцаа холбооны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалт:**

“3.1.13.“дугаартайгаа шилжих үйлчилгээ” гэж хэрэглэгч нэг цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчийн бүртгэлээс гарч бусад цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчид бүртгүүлэн хэрэглэгч болох үедээ одоогийн ашиглаж байгаа дугаараа шилжүүлэн хэрэглэх боломж олгох үйлчилгээ.”

#### **2/8 дугаар зүйлийн 8.13 дахь хэсэг:**

“8.13.Зохицуулах хороо нь хуульд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлж болно.”

#### **3/9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалт:**

“9.1.13.дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, уг үйлчилгээтэй холбоотой зохицуулалтын журам батлах;”

#### **4/25 дугаар зүйлийн 25.2.9 дэх заалт:**

“25.2.9.хэрэглэгч дугаартайгаа цахилгаан холбооны үйлчлэгч хооронд шилжих техникийн боломж бүрдүүлэх;”

**2 дугаар зүйл.**Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын дугаарыг “9.1.14” гэж, 25 дугаар зүйлийн 25.2.9 дэх заалтын дугаарыг “25.2.10” гэж тус тус өөрчилсүгэй.



**3 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ**  
/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосыг эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### **2 дугаар зүйл.Газрын тосны тухай хууль тогтоомж**

2.1.Газрын тосны тухай хууль тогтоомж нь энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон харилцаанд энэ хууль үйлчилнэ.

### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“газрын тос” гэж газрын хэвлийд болон агаарын хэвийн даралт, хэмд хатуу, шингэн, хийн төлөвт орших нүүрс-устөрөгчийн нэгдэл /түүхий тос, байгалийн хий/-ийг;



4.1.2. “түүхий тос” гэж газрын хэвлийд болон агаарын хэвийн даралт, хэмд шингэн төлөвт орших нүүрс-устөрөгчийн нэгдлийг;

4.1.3. “байгалийн хий” гэж газрын хэвлийд болон агаарын хэвийн даралт, хэмд хийн төлөвт дангаар орших нүүрс-устөрөгчийн нэгдлийг;

4.1.4. “уламжлалт бус газрын тос” гэж байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийтэй элс, хийтэй занар, нүүрсний давхаргын метан хийг;

4.1.5. “нүүрсний давхаргын метан хий” гэж нүүрсжих явцад нүүрсэнд хуримтлагдсан хийг;

4.1.6. “газрын тостой холбогдсон үйл ажиллагаа” гэж газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх, хайх, ашиглах, хадгалах, тээвэрлэх, борлуулах, татан буулгахтай холбогдсон үйл ажиллагааг;

4.1.7. “эрэл” гэж тодорхой нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлөвийг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизикийн тойм судалгааны ажлыг;

4.1.8. “хайгуул” гэж газрын тосны орд нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизик, өрөмдлөг, олборлолтын туршилтын ажлыг;

4.1.9. “үнэлгээ” гэж нээлтийн цооногоор илрүүлсэн хуримтлал нь үр ашигтай нээлт болох эсэхийг тодорхойлох зорилгоор хийх ажлыг;

4.1.10. “хайгуулын талбай” гэж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хайгуул хийхээр зарласан талбайг;

4.1.11. “гэрээлэгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулсан компанийг;

4.1.12. “оператор компани” гэж гэрээлэгчийн газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч компанийг;

4.1.13. “туслан гүйцэтгэгч” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгэхээр гэрээлэгчтэй, эсхүл



оператор компанитай гэрээ байгуулсан, Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээдийг;

4.1.14. “бүтээгдэхүүн хуваах гэрээ” гэж энэ хуулийн хүрээнд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгчийн хооронд байгуулсан гэрээг;

4.1.15. “ашиглалтын талбай” гэж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ашиглалтын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн талбайг;

4.1.16. “ашиглалт” гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглалтын бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагааг;

4.1.17. “бүтээн байгуулалт” гэж олборлолтын байгууламж, дамжуулах хоолой, дэд бүтцийг хүргэлтийн цэг хүртэл барихыг;

4.1.18. “олборлолт” гэж хүргэлтийн цэг хүртэлх бүтээн байгуулалтаас бусад олборлохтой холбогдсон бүх үйл ажиллагааг;

4.1.19. “татан буулгалт” гэж бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа дуусгавар болох үед гэрээлэгчээс байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, барьсан барилга байгууламжийг татан буулгах, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг;

4.1.20. “нээлтийн цооног” гэж газрын тосны хуримтлалыг илрүүлсэн цооногийг;

4.1.21. “нээлт” гэж хайгуулын цооногоор тогтоосон газрын тосны хуримтлалыг;

4.1.22. “олборлолтын туршилт” гэж эдийн засгийн үр ашгийг тогтоох зорилгоор гүйцэтгэх энэ хуулийн 22.4-т заасан хугацааны олборлолтыг;

4.1.23. “газрын тосны орд” гэж геологийн хувьсал, өөрчлөлтөөр газрын хэвлийд үүссэн, чанар, нөөц нь тогтоогдсон газрын тосны хуримтлал бүхий бүтэц, давхарга зүйн онцлогоор төстэй нэг буюу хэд хэдэн хураагуурыг;

4.1.24. “үр ашигтай нээлт” гэж тухайн үеийн техник, технологийн түвшинд ашиглахад эдийн засгийн үр ашигтай газрын тосны хуримтлал бүхий хураагуурыг;





4.1.25.“хүргэлтийн цэг” гэж Засгийн газар болон гэрээлэгчид гэрээний дагуу ногдох газрын тосыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хэмжиж, хуваах цэгийг;

4.1.26.“нөөц ашигласны төлбөр” гэж олборлосон газрын тосонд ногдуулах төлбөрийг;

4.1.27.“хайгуулын ажлын зардал” гэж энэ хуулийн 4.1.8-д заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг;

4.1.28.“бүтээн байгуулалтын зардал” гэж энэ хуулийн 4.1.17-д заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг;

4.1.29.“үйл ажиллагааны зардал” гэж ашиглалтын талбайд бүтээн байгуулалтын болон татан буулгалттай холбогдон гарсан зардлаас бусад газрын тос олборлохтой холбогдон гарах зардлыг;

4.1.30.“татан буулгалтын зардал” гэж бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа дуусгавар болох үед гэрээлэгчээс байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, олборлолтын цооногийг хаах, барилга байгууламжийг татан буулгах, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг;

4.1.31.“өртөг нөхөгдөх зардал” гэж хайгуул, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, татан буулгалтын зардлын нийлбэрийг;

4.1.32.“өртөгт газрын тос” гэж газрын тосноос энэ хуулийн 4.1.31-д заасан зардлыг нөхөхөд зориулж энэ хуулийн 32.3-т заасан хувиар тооцсон газрын тосыг;

4.1.33.“ашигт газрын тос” гэж хүргэлтийн цэг дээр хэмжсэн нийт газрын тосноос энэ хуулийн 4.1.26, 4.1.32-т заасан газрын тосыг хасаад Засгийн газар болон гэрээлэгчийн хооронд хуваах газрын тосыг.

## **5 дугаар зүйл.Газрын тосны өмчлөл**

5.1.Газрын хэвлий болон гадаргуу дээр байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тос, уламжлалт бус газрын тос нь төрийн өмчид хамаарна.

5.2.Төр газрын тос, уламжлалт бус газрын тос хайх, ашиглах зөвшөөрөл олгох замаар өмчлөх эрхээ хэрэгжүүлнэ.



**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН УДИРДЛАГЫН  
БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

**6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1. Улсын Их Хурал газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг батлах;

6.1.2. улсын тусгай хамгаалалттай газар нутаг бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэх;

6.1.3. Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар тодорхой нутаг дэвсгэрт бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахыг хуулийн дагуу хязгаарлах, эсхүл хориглох.

**7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

7.1. Засгийн газар газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

7.1.2. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу газрын тосны салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих;

7.1.3. энэ хуулийн 6.1.2-т зааснаас бусад тусгай хэрэгцээний газарт бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэх;

7.1.4. нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах; газрын тосны бүртгэл, тооцоо; газрын тосны салбарыг хөгжүүлэх сан; уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг батлах;

7.1.5. нөөц ашигласны төлбөр, ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хэсгийг гэрээлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр газрын тос, уламжлалт бус газрын тосны биет бүтээгдэхүүн болон мөнгөн хэлбэрээр төвлөрүүлэх;



7.1.6.Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг эдлэх;

7.1.7.улсын хил дамнасан газрын тосны хуримтлал бүхий хураагуур, газрын тосны орд тогтоогдсон тохиолдолд түүнийг Засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулах;

7.1.8.бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, цуцлах эрхийг олгох, бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гэрээлэгчийн хүлээсэн эрх, үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

7.1.9.улсын хилийн зурваст газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулах асуудлыг шийдвэрлэх;

7.1.10.газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын талбайтай бусад ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбай давхацсан тохиолдолд нийгэм, эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлэн шийдвэрлэх;

7.1.11.газрын тос борлуулах зориулалт бүхий дамжуулах хоолой барих зөвшөөрөл олгох;

7.1.12.бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг батлах;

7.1.13.энэ хуулийн 11.2.17-д заасан гэрээний загварыг батлах.

## **8 дугаар зүйл.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

8.1.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ газрын тосны асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах;

8.1.2.газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

8.1.3.газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны



эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах;

8.1.4.хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах;

8.1.5.хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох, хугацааг нь сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

8.1.6.газрын тосны нөөцийн тооцооны тайлан, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах;

8.1.7.газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд холбогдох байгууллагатай хамтран шалгалт хийх;

8.1.8.газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

8.1.9.газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах;

8.1.10.газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох;

8.1.11.газрын тос борлуулах зориулалт бүхий дамжуулах хоолой барих саналыг Засгийн газарт өргөн мэдүүлэх.

## **9 дүгээр зүйл.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

9.1.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/ газрын тосны асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;



9.1.2.хайгуулын талбайд захиалга хүлээн авах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, энэ хуулийн 7.1.8-д заасны дагуу бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах;

9.1.3.газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;

9.1.4.тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрх, үүргээ биелүүлэхтэй нь холбогдсон асуудлаар зөвлөгөө, чиглэл өгөх;

9.1.5.газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийн хөдөлгөөнийг хянах, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлэх;

9.1.6.ашиглалтын талбайн хэмжээ, түүний хилийн заагийн булангийн цэгийн солбицлыг гэрээлэгчтэй харилцан тохиролцох;

9.1.7.газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт гаргах;

9.1.8.гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж нэгтгэх;

9.1.9.газрын тосны борлуулалтын орлогоос Засгийн газарт ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх;

9.1.10.хайгуул, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны геологи, геофизик, гидрогеологи, геохими, өрөмдлөг, хайгуул, ашиглалттай холбогдсон үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах;

9.1.11.газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, хүлээн авах;

9.1.12.газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын тайлан боловсруулах журам батлах, мөрдүүлэх;

9.1.13.хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь буцаан авах ажлыг зохион байгуулах;

9.1.14.байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тосны хураагуурын орон зайд газрын тос хадгалах зөвшөөрөл олгох;



9.1.15.газрын тос, уламжлалт бус газрын тосыг тээвэрлэх асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах;

9.1.16.газрын тосны барилга байгууламж, дамжуулах хоолойн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулах, дүгнэлт гаргуулах;

9.1.17.туслан гүйцэтгэгчээр хийлгэх ажлын техникийн шаардлагыг хянах;

9.1.18.газрын тосны хуримтлал, орд нь хоёроос дээш хайгуул, ашиглалтын талбай дамнасан тохиолдолд энэ хуулийн 25.5, 25.6-д заасны дагуу зохицуулах;

9.1.19.газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах стандарт, дүрэм, журам, зааврыг боловсруулж батлуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.20.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааг хуульд заасан үндэслэлээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоох, тус шийдвэрээ төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан мэдэгдсэн байх;

9.1.21.бүтээгдэхүүн хуваах гэрээг өөрчлөх саналыг төрийн захиргааны төв байгууллагад гаргах;

9.1.22.гэрээлэгч нь хайгуулын хугацаанд байгалийн хий хайх үүргээ биелүүлээгүй бол тухайн талбайд байгалийн хийн чиглэлээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлах;

9.1.23.хуульд заасан бусад чиг үүрэг.

## **10 дугаар зүйл.Нутгийн удирдлагын байгууллагын эрх, үүрэг**

10.1.Нутгийн захиргааны байгууллага газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах.

10.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



10.2.1.төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн газрын тосны хайгуул явуулах талбайг зарлах тухай мэдэгдлийг хэлэлцэн дүгнэлт гаргах;

10.2.2.энэ хуулийн 10.2.1-д заасан дүгнэлт гаргахдаа зөвхөн хуульд заасан үндэслэлээр татгалзах;

10.2.3.татан буулгалтын ажлын үр дүнг хүлээн авах комиссын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах.

10.3.Сум, дүүргийн Засаг дарга газрын тосны асуудлаар дараах үүргийг хэрэгжүүлнэ:

10.3.1.харьяалах нутаг дэвсгэртээ тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах, эзэмшүүлэхэд хяналт тавих, зөрчил гаргавал зөрчлийг таслан зогсоох, арилгуулах;

10.3.2.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хуулиар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих.

10.4.Нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчид дараах шаардлага тавихыг хориглоно:

10.4.1.энэ хууль, бүтээгдэхүүн хуваах гэрээ болон сум, дүүргийн Засаг даргатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд заагаагүй аливаа хөрөнгө оруулалт хийлгүүлэх;

10.4.2.хүмүүнлэгийн зорилгоос бусад зорилгоор аливаа хандив, тусламж шаардах, санхүүжилт хүсэх;

10.4.3.улс төрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор аливаа санхүүжилт гаргуулах.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭРЭЭЛЭГЧ**

#### **11 дүгээр зүйл.Гэрээлэгчийн эрх, үүрэг**

11.1.Гэрээлэгч дараах эрх эдэлнэ:

11.1.1.гэрээний дагуу энэ хуулийн 7.1.5, 7.1.6-д зааснаас бусад өөрт ногдох газрын тосыг захиран зарцуулах;



11.1.2.гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ энэ хуульд заасны дагуу бусдад шилжүүлэх;

11.1.3.шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны байгууллагын зөвшөөрснөөр жилийн төлөвлөгөө, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах;

11.1.4.энэ хуулийн 13.1-д заасан үүргээ бүрэн биелүүлсэн бол эскроу дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан авах;

11.1.5.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд хайгуулын талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буцаах;

11.1.6.гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байх.

11.2.Гэрээлэгч дараах үүрэг хүлээнэ:

11.2.1.Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдөж, гэрээнд заасан үүргээ биелүүлэх;

11.2.2.гэрээнд заасан үйл ажиллагааг явуулах;

11.2.3.жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх;

11.2.4.Засгийн газар энэ хуулийн 7.1.6-д заасан давуу эрх эдлэх тохиолдолд бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн үнэ, нөхцөлөөр нийлүүлэх;

11.2.5.өөрийн үйл ажиллагаанд шаардагдах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгохдоо Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид тэргүүн ээлжинд давуу эрх олгох.

11.2.6.хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах;

11.2.7.үйл ажиллагаандаа дэвшилтэт технологи нэвтрүүлэх, Монгол Улсын иргэн-мэргэжилтэн, мэргэжлийн ажилчдыг ажилд авах, сургах, дадлагажуулах, газрын тосны салбарт хэрэгжүүлж





байгаа үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд таниулахад төрийн захиргааны байгууллагатай хамтарч ажиллах;

11.2.8.ижил төрлийн ажил хөдөлмөр эрхлэгч гадаад, дотоодын ажилтны цалин, урамшууллыг тэгш тогтоох, түүнчлэн ажилтны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

11.2.9.байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах;

11.2.10.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг стандартын дагуу бүрэн хийж дуусгах, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах ажлын зардлыг гаргах;

11.2.11.хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах автомашин, техник, тоног төхөөрөмж, материал түүхий эд, сэлбэг хэрэгсэл, газрын тосны бүтээгдэхүүнийг импортлохдоо тэдгээрийн нэр төрөл, тоо хэмжээ, нэгж үнийн мэдээлэл, түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт барьж байгуулах барилга байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичгийг төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх;

11.2.12.төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр хайгуул, ашиглалттай холбогдсон анхдагч болон үр дүнгийн тайлан, материалыг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;

11.2.13.газрын тосны нөөцийн хөдөлгөөний тооцоог жил бүр гаргаж, төрийн захиргааны байгууллагаар хянуулах;

11.2.14.санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог энэ хуулийн 7.1.4-т заасан журмын дагуу үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх;

11.2.15.үйл ажиллагааных нь явцад түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд тухайн газарт явуулж байгаа үйл ажиллагаагаа зогсоон, нэн даруй холбогдох байгууллагад мэдэгдэх;

11.2.16.үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулалт, өмчлөлтэй холбоотой аливаа мэдээллийг Засгийн газрын хүсэлтээр гарган өгөх;



11.2.17.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах;

11.2.18.газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад байгаль орчин, нөхөн сэргээлт, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах асуудлаар тогтмол мэдээлэх үүрэг бүхий ажилтантай байх;

11.2.19.газрын тосыг орон нутаг, улсын болон олон улсын чанартай замд хүргэх замын төрөл түүнчлэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгахад шаардагдах хөрөнгийг орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах;

11.2.20.гэрээлэгч нь техникийн осол, саатал, алдагдал урт хугацаанд үргэлжлэн санхүүгийн хүнд байдалд орсон нь тогтоогдсон, шүүхийн шийдвэр болон улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг зогсоосон, давагдашгүй хүчин зүйл, бусад шалтгаанаар хайгуул, бүтээн байгуулалт, ашиглалт, экспортын үйл ажиллагааг зогсоохдоо газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан мэдэгдэх.

11.3.Монгол Улсын аж ахуйн нэгжийн хүрэлцээ, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхэд тавигдаж байгаа шаардлагад нийцэхгүйгээс шалтгаалан гэрээлэгч энэ хуулийн 11.2.5-д заасан үүргээ биелүүлэх боломжгүй болсон бөгөөд түүнийг зохих ёсоор нотолсон бол төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр уг үүргээс бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж болно.

11.4.Оператор компани нь Компанийн тухай хуульд<sup>1</sup> заасан эрх, үүргээс гадна энэ хуулийн 11.2.1-11.2.8, 11.2.12-11.2.20-д заасан үүргийг хүлээнэ.

11.5.Туслан гүйцэтгэгч нь Компанийн тухай хуульд заасан эрх, үүргээс гадна энэ хуулийн 11.2.1, 11.2.7, 11.2.10-11.2.12, 11.2.15-д заасан үүргийг хүлээнэ.

## **12 дугаар зүйл.Гэрээг цуцлах**

12.1.Бүтээгдэхүүн хуваах гэрээг доор дурдсан үндэслэлээр Засгийн газрын шийдвэрээр цуцална:

<sup>1</sup>Компанийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн



12.1.1.хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд ноцтой хохирол учруулсан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ удаа дараа хэрэгжүүлээгүй нь эрх бүхий төрийн байгууллагаар тогтоогдсон;

12.1.2.захиалгын баримт бичиг болон хэлэлцээ хийх явцад нэмж ирүүлсэн баримт бичиг нь хууль бус болохыг эрх бүхий байгууллага гэрээ батлагдсанаас хойш тогтоосон;

12.1.3.газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар гэрээлэгч худал мэдээ, мэдээлэл, тайлан өгснөөс улсад үлэмж хэмжээний хохирол учирсан болох нь эрх бүхий төрийн байгууллагаар тогтоогдсон;

12.1.4.хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах эрх, үүргээ гэрээлэгч хууль бусаар шилжүүлсэн, энэ хуулийн 34.7, 34.8-д заасан эрх, үүргээ шилжүүлэхдээ энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд холбогдох төлбөрийг шилжүүлээгүй;

12.1.5.гэрээлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу удаа дараа ноцтой зөрчсөн;

12.1.6.гэрээлэгч нь энэ хуулийн 14.7-д заасан төлбөрийн хэмжээг худал мэдээлсэн.

12.2.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалт явуулах нь эдийн засгийн үр ашиггүй гэж үзсэн, эсхүл онц байдал, давагдашгүй хүчин зүйл нэг ба түүнээс дээш жил үргэлжилбэл гэрээг цуцлах хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад хүргүүлж болно.

12.3.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 12.2-т заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ.

12.4.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 12.3-т заасан дүгнэлтийг 30 хоногийн дотор хянан үзэж, холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

12.5.Энэ хуулийн 12.1-д заасан үндэслэлээр бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан тохиолдолд хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг нөхөж олгохгүй бөгөөд энэ хуулийн 11.2.9-д зааснаар эскроу дансанд байршуулсан мөнгийг байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, шаардлагатай тохиолдолд хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгахад зарцуулж, үлдсэн мөнгийг гэрээлэгчид буцаан олгоно.



### **13 дугаар зүйл. Гэрээний биелэлтийг дүгнэх**

13.1. Гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр гэрээг цуцлах тохиолдолд төрийн захиргааны байгууллага гэрээний биелэлтийг дараах үзүүлэлтээр дүгнэнэ:

13.1.1. гэрээлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэх;

13.1.2. гэрээлэгч байгаль орчны нөхөн сэргээлтийг бүрэн хийж дуусгасан эсэх;

13.1.3. гэрээлэгч хууль тогтоомжийн дагуу төлөх ёстой татвар, төлбөр, хураамжийг төлж барагдуулсан эсэх;

13.1.4. гэрээлэгч эд хөрөнгийн өмчлөлийг шийдвэрлэсэн эсэх;

13.1.5. гэрээлэгч хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах асуудлыг шийдвэрлэсэн эсэх;

13.1.6. энэ хуулийн 11.2.10-т заасан үүргийн биелэлт.

13.2. Төрийн захиргааны байгууллага гэрээний биелэлтийг дүгнэхдээ холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна.

13.3. Гэрээг хангалттай биелүүлсэн гэж дүгнэсэн бол энэ хуулийн 11.1.4-т заасан эрх үүснэ.

### **14 дүгээр зүйл. Гэрээлэгч эрх, үүргээ бусдад шилжүүлэх**

14.1. Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг бүхлээр нь, эсхүл гуравны нэг буюу түүнээс дээш хувийг Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх эрхгүй.

14.2. Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг бусдад шилжүүлэх тохиолдолд хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад гаргана.

14.3. Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 14.2-т заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ.

14.4. Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 14.3-т заасан дүгнэлтийг хянан үзээд 30 хоногийн дотор Засгийн газарт саналаа хүргүүлж, холбогдох шийдвэр гаргуулна.



14.5.Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх тохиолдолд гэрээлэгч, төрийн захиргааны байгууллага болон гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээдийн хооронд гурван талт гэрээ байгуулна.

14.6.Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг шилжүүлэх Засгийн газрын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 34.7, 34.8-д заасан төлбөрийг төлнө.

14.7.Гэрээлэгч болон гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээд эрх, үүрэг шилжүүлэхэд төлсөн төлбөрийн хэмжээг шударгаар мэдээлнэ.

14.8.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 14.3-т заасан дүгнэлт гаргахдаа хайгуул хийсэн хугацаанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлсэн эсэх талаарх байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн нутгийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг харгалзан үзнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЭРЭЛ**

### **15 дугаар зүйл.Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл**

15.1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажлыг хуулийн этгээд төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгэнэ.

15.2.Улсын тусгай хамгаалалттай газраас бусад улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хийж болно.

15.3.Нэг хуулийн этгээдэд олгох газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн талбайн хэмжээг газрын тосны сав газрын геологийн тогтоцыг харгалзан төрийн захиргааны байгууллага тогтооно.

15.4.Шатдаг занарын эрлийн үед өрөмдлөг хийж болно.

### **16 дугаар зүйл.Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хийх хүсэлт гаргах**

16.1.Хуулийн этгээд газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хийх хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад гаргана.



16.2.Энэ хуулийн 16.1-д заасан хүсэлтэд дараах зүйлийг заана:

- 16.2.1.эрэл хийх талбайн байршил, хэмжээ;
- 16.2.2.эрлийн хугацаанд хийх ажлын ерөнхий хөтөлбөр;
- 16.2.3.техникийн хүчин чадал, хүний нөөцийн чадавч;
- 16.2.4.төлөвлөсөн ажлыг санхүүжүүлэх санхүүгийн

боломж, эх үүсвэр;

16.2.5.тухайн жилд гүйцэтгэх эрлийн ажлын төлөвлөгөө, төсөл.

16.3.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 16.1-д заасан эрэл хийх хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн хугацаанд судалж, шийдвэр гаргана.

16.4.Тухайн талбайд эрэл хийх хүсэлтийг хоёр ба түүнээс дээш хуулийн этгээд гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага харьцуулсан дүгнэлт хийж, шийдвэр гаргана.

16.5.Төрийн захиргааны байгууллага эрэл хийх шийдвэр гаргахдаа дараах нөхцөлийг харгалзана:

16.5.1.хүсэлт гаргагч нь техник, технологи, мэргэжлийн болон санхүүгийн чадавхтай эсэх;

16.5.2.эрлийн ажлын арга, аргачлал нь олон улсын жишигт нийцсэн эсэх;

16.5.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө.

16.6.Энэ хуулийн 16.3, 16.4-т заасан шийдвэрийг үндэслэн газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх гэрээг гурав хүртэл жилийн хугацаагаар байгуулна.

16.7.Эрлийн гэрээний эрх, үүргийг өөр этгээдийн нэр дээр шилжүүлэхийг хориглоно.

## **17 дугаар зүйл.Эрлийн ажлын үр дүн, бүтээгдэхүүн хуваах гэрээ**

17.1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хийсэн этгээд нь эрлийн ажлын анхдагч материал, үр дүнгийн тайлан мэдээг төрийн захиргааны байгууллагад өгч дүгнэлт гаргуулах үүрэгтэй.



17.2.Эрэл хийсэн этгээд нь эрлийн ажлын үр дүнгийн тайланг төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулснаас хойш 60 хоногийн хугацаанд газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах саналаа ирүүлнэ.

17.3.Эрэл хийсэн этгээд доор дурдсан нөхцөлийг тусгасан бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг боловсруулж төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:

17.3.1.ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хувь;

17.3.2.нөөц ашигласны төлбөрийн хувь;

17.3.3.өртөгт газрын тосны хязгаарын хувь;

17.3.4.хайгуулын хөрөнгө оруулалтын хэмжээ;

17.3.5.байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ;

17.3.6.сургалтын урамшууллын хэмжээ;

17.3.7.гэрээнд гарын үсэг зурсны урамшууллын хэмжээ;

17.3.8.олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ;

17.3.9.олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ;

17.3.10.орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ;

17.3.11.төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг;

17.3.12.Засгийн газарт санал болгох бусад ашигтай нөхцөл.

17.4.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 17.3-т заасан төслийг хүлээн авмагц энэ хуулийн 17.3, 21.2, 26.3-т заасан этгээдтэй 60 хоногийн дотор гэрээний төслийн талаар хэлэлцээ хийж эцэслэн тохиролцсон төслийг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

17.5.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 17.4-т заасан гэрээний төслийг 30 хоногийн дотор хянаж үзээд саналаа Засгийн газарт хүргүүлэх бөгөөд Засгийн газар уг саналыг хүлээж авснаас хойш 60 хоногийн дотор гэрээ байгуулах эсэх талаар шийдвэр гаргана.

17.6.Засгийн газар гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төрийн захиргааны байгууллага 30 хоногийн дотор гэрээ байгуулж энэ талаар нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

17.7.Энэ хуулийн 17.4-т заасан хэлэлцээ хийх явцад талууд тохиролцоонд хүрч чадаагүй бол газрын тосны эрлийн талбайг энэ хуулийн 19.1-д заасны дагуу хайгуулын талбайгаар зарлана.

17.8.Нэг талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалт явуулах тохиолдолд гэрээлэгч нь нэг байж болох бөгөөд төрөл тус бүрээр нь гэрээ байгуулж, тусгай зөвшөөрөл авна.



## ТАВДУГААР БҮЛЭГ ХАЙГУУЛ

### 18 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, сунгах

18.1.Энэ хуулийн 17.6-д заасан гэрээлэгч нь хайгуулын тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

18.2.Хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

18.2.1.бүтээгдэхүүн хуваах гэрээний хуулбар;

18.2.2.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

18.2.3.тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө;

18.2.4.энэ хуулийн 11.2.9-д заасан мөнгөн хөрөнгийг байршуулсан баримт.

18.3.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 18.1, 18.2-т заасан баримт бичгийг хянан үзэж, хайгуулын тусгай зөвшөөрлийг хайгуулын хугацаагаар дараах этгээдэд олгож, сунгана:

18.3.1.эрлийн ажлын үр дүнд бүтээгдэхүүн хуваах гэрээ шууд байгуулсан;

18.3.2.энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан.

18.4.Газрын тосны хайгуулын хугацаа найм хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно.

18.5.Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа арав хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

18.6.Бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулсан өдрөөс хайгуулын хугацааг тооцно.

18.7.Хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн хугацааг хуанлийн жилээр тооцно.

18.8.Төрийн захиргааны байгууллага эхний жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан өдрөөс





хойш 120 хоногийн дотор, дараагийн жилээс хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг тухайн жилийн эхний улиралд багтаан батална.

18.9.Төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 18.3-т заасан хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болох бөгөөд энэ тохиолдолд гэрээлэгч доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, төрийн захиргааны байгууллагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад хугацаа сунгах хүсэлтээ ирүүлнэ:

18.9.1.хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан;

18.9.2.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;

18.9.3.сунгасан хугацаанд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл;

18.10.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 18.9-д заасан баримт бичгийг хянаж хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл энэ хуульд заасан хугацаагаар сунгана.

18.11.Төрийн захиргааны байгууллага нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

18.12.Хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгэх үүргээ хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй тохиолдолд хайгуулын хугацааг сунгахгүй.

### **19 дүгээр зүйл.Хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах**

19.1.Төрийн захиргааны байгууллага доор дурдсан хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлана:

19.1.1.улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн болон төрийн захиргааны байгууллагаас ялгасан талбай;

19.1.2.эрэл хийсэн этгээд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахаас татгалзсан;

19.1.3.урьд нь хайгуулын тусгай зөвшөөрөл авсан этгээд хайгуул хийхээс татгалзаж талбайгаа буцааж өгсөн, эсхүл удаа дараа



зөрчил гаргаснаас эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон;

19.1.4.хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж талбайг буцаан авсан;

19.1.5.энэ хуулийн 9.1.22, 11.1.5, 17.7 -д болон 12 дугаар зүйлд зааснаар тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан;

19.1.6. хуульд заасан бусад.

19.2.Төрийн захиргааны байгууллага хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гурваас доошгүй удаа зарлана.

19.3.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын талбайн хэмжээг газрын тосны сав газрын геологийн тогтоцыг харгалзан газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

## **20 дугаар зүйл.Хайгуулын талбайн захиалга хүлээн авах**

20.1.Хайгуулын талбайн захиалга хүлээн авах хугацаа 60 хүртэл хоног байх бөгөөд хайгуулын талбайд эхний захиалга хүлээн авсан өдрөөс хойш тав хоногийн дотор захиалга хүлээн авах эцсийн хугацааг төрийн захиргааны байгууллага зарлана.

20.2.Хайгуулын талбайн захиалгыг төрийн захиргааны байгууллагад битүүмжлэн ирүүлэх ба түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

20.2.1.захиалагчийн эрх зүйн байдлыг нотлох баримт бичиг;

20.2.2.захиалагч, түүний хөрөнгө оруулагчийн танилцуулга;

20.2.3.захиалагчийг төлөөлөх хүний овог, нэр, албан тушаал, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг, түүнд эрх олгосныг нотлох баримт;

20.2.4.захиалагчийн техник, тоногтөхөөрөмж, мэргэжлийн чадварыг нотлох баримт бичиг;

20.2.5.хайгуулын ажилд зарцуулах хөрөнгийн баталгаа;

20.2.6.хайгуулын хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсөв;



20.2.7.энэ хуулийн 34.5-д заасан үйлчилгээний хөлсийг төлсөн баримт;

20.2.8.захиалагч нь түншлэл байвал түүний оролцогч талуудын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, оролцох хувь, хэмжээ.

20.3.Төрийн захиргааны байгууллага хайгуулын талбайн захиалга хүлээн авсан эсэх талаар ажлын таван өдрийн дотор захиалагчид бичгээр мэдэгдэнэ.

20.4.Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага захиалагчийн талаарх мэдээллийг гэрээ байгуулах хүртэл гуравдагч этгээдэд задруулахгүй.

## **21 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтын дүнг гаргах**

21.1.Төрийн захиргааны байгууллага гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу үнэлгээ хийж энэ хуулийн 17.3-т заасан үндсэн нөхцөлөөс Засгийн газарт хамгийн ашигтай санал ирүүлсэн захиалагчийг ялагчаар тодруулан энэ тухай сонгон шалгаруулалтад оролцогчдод мэдээлнэ.

21.2.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 21.1-д заасан сонгон шалгаруулалтын ялагчтай бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг тохиролцож, энэ хуулийн 17.5-д заасан шийдвэр гарсан тохиолдолд энэ хуулийн 17.6-д заасны дагуу бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулна.

## **22 дугаар зүйл. Үнэлгээ, олборлолтын туршилт**

22.1.Гэрээлэгч хайгуулын цооногоос газрын тос илэрснээс хойш 15 хоногийн дотор энэ тухай төрийн захиргааны байгууллагад албан ёсоор мэдэгдэж, цооногийг бүртгүүлнэ.

22.2.Гэрээлэгч цооногийг бүртгүүлсэн өдрөөс хойш 90 хоногийн дотор уг цооног туршилт, судалгааны ажлыг гүйцэтгэн нээлтийн цооног мөн эсэхийг тодорхойлж, төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх бөгөөд газрын тосны нээлтийн цооног бүртгэгдсэн тохиолдолд 90 хоногийн дотор үнэлгээний хөтөлбөр, төслийг төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

22.3.Гэрээлэгч үнэлгээний хөтөлбөрөөр үр ашигтай нээлт мөн эсэхийг тогтоож, нөөцийн үнэлгээг тусгасан үнэлгээний ажлын тайланг үнэлгээний ажил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.



22.4.Цооногийн олборлолтын туршилтын хугацаа 180 хоногоос хэтрэхгүй байна.

22.5.Олборлолтын туршилтаар олборлосон түүхий тосыг худалдаж, экспортолж болох бөгөөд нөөц ашигласны төлбөр, ашигт газрын тосны хэмжээг бүтээгдэхүүн хуваах гэрээгээр зохицуулна.

22.6.Олборлолтын туршилтын хугацаа дууссанаас хойш ашиглалт эхэлтэл тухайн цооногийн олборлолтыг зогсооно.

### **23 дугаар зүйл.Баялаг, нөөц**

23.1.Гэрээлэгч баялгийн үнэлгээ, нөөцийн тооцоог энэ хуулийн 8.1.3-т заасан газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

23.2.Гэрээлэгч нөөцийн тооцооны тайланг хайгуулын хугацаа дуусахаас 90 хоногийн өмнө төрийн захиргааны байгууллагаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, төрийн захиргааны төв байгууллагаар нөөцийг хүлээн авах эсэх талаар шийдвэр гаргуулна.

23.3.Төрийн захиргааны төв байгууллага Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг батална.

23.4.Гэрээлэгч болон төрийн захиргааны байгууллагын хүсэлтээр нөөцийн тооцоо, эдийн засгийн үнэлгээ, газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөндлөнгийн байгууллага, эсхүл шинжээчээр дүгнэлт гаргуулахтай холбогдон гарах зардлыг гэрээлэгч хариуцна.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ АШИГЛАЛТ**

### **24 дүгээр зүйл.Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, сунгах**

24.1.Газрын тосны нөөцийг хүлээн авах тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гэрээлэгч ашиглалтын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргана.

24.2.Гэрээлэгч ашиглалт эхлэхээс өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл авах бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс ашиглалтын хугацаа эхэлнэ.



24.3.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг холбогдох хуулийн дагуу төрийн захиргааны төв байгууллага гэрээлэгчид олгож, сунгана.

24.4.Гэрээлэгч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад дараах баримт бичгийг бүрдүүлж төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ:

24.4.1.газрын тосны нөөц бүртгэсэн тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;

24.4.2.тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл;

24.4.3.орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө;

24.4.4.ашиглалтын үеийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;

24.4.5.эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас баталсан нэг загварын байр зүйн зураг дээр ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг градус, секундээр тодорхойлж тэмдэглэсэн зураг;

24.4.6.энэ хуулийн 11.2.9-д заасан мөнгөн хөрөнгийг байршуулсан баримт.

24.5.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдолд гэрээлэгч дараах баримт бичгийг бүрдүүлэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ:

24.5.1.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлт, үндэслэл;

24.5.2.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан;

24.5.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;

24.5.4.тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл.

24.6.Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 90 хоногийн дотор энэ хуулийн 24.4.5-д заасны дагуу ашиглалтын талбайн хилийн хэмжилт хийж, шав тэмдэг тавих ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.



24.7.Төрийн захиргааны төв байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

## **25 дугаар зүйл.Газрын тосны ашиглалт**

25.1.Гэрээлэгч хайгуулын хугацаа дууссанаас хойш 90 хоногийн дотор ашиглалтын үйл ажиллагаа явуулах эсэх тухай хүсэлт гаргаагүй тохиолдолд бүтээгдэхүүн хуваах гэрээг дуусгавар болгож, тухайн талбайд ашиглалт явуулах этгээдийг энэ хуулийн 20, 26 дугаар зүйлд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар тодруулна.

25.2.Газрын тосны ашиглалтын хугацаа 25 хүртэл жил байх бөгөөд гэрээлэгч ашиглалтын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага тав хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно.

25.3.Уламжлалт бус газрын тосны ашиглалтын хугацаа 30 хүртэл жил байх бөгөөд гэрээлэгч ашиглалтын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага нэг удаа тав хүртэл жилээр сунгаж болно.

25.4.Гэрээлэгч бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхдээ дэд бүтэц, байгаль орчны асуудлаар холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас зохих зөвшөөрөл авна.

25.5.Газрын тосны орд, газрын тосны хуримтлалтай хураагуур нь хоёр ба түүнээс дээш, ашиглалтын талбайн хил заагийг дамнан байрших тохиолдолд гэрээлэгчид нь хамтран ашиглах гэрээ байгуулан ашиглалтын нэгдсэн төлөвлөгөө, төсөв боловсруулж төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

25.6.Гэрээлэгч нь энэ хуулийн 25.5-д заасныг хэрэгжүүлэхээс татгалзсан тохиолдолд тухайн газрын тосны хуримтлалтай хураагуурыг хэрхэн ашиглах талаарх шийдвэрийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох хууль тогтоомж, шинжлэх ухааны аргачлалд үндэслэн шийдвэрлэнэ.

25.7.Гэрээлэгч ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 60 хоногийн дотор ашиглалтын эхний жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

25.8.Гэрээлэгч ашиглалтын хоёр дахь жилээс эхлэн тухайн жилийн ашиглалтын төлөвлөгөө, төсвийн төслийг хуанлийн өмнөх жил дуусахаас 90 хоногийн өмнө төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.



25.9.Гэрээлэгч баталгаат нөөцөөс ашиглалтын үйл ажиллагааг явуулах бөгөөд энэ хэсэг олборлолтын туршилтад хамаарахгүй.

25.10.Гэрээлэгч газрын тосны ордын нөөцийг ашиглах дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ.

## **26 дугаар зүйл.Ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах**

26.1.Дараах тохиолдолд ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлана:

26.1.1.газрын тосны нөөцийг хүлээн авсан тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсны дараа хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаагүй;

26.1.2.улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг тогтоосон;

26.1.3.өмнөх ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үйл ажиллагаа явуулахаас татгалзаж талбайг буцааж өгсөн;

26.1.4.өмнөх ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль тогтоомж зөрчсөний улмаас түүний ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон талбайг буцаан авсан;

26.1.5.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж талбайг буцааж авсан;

26.1.6.шүүхийн шийдвэрээр ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан талбайд энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, гэрээлэгчийг сонгон шалгаруулна.

26.3.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26.2-т заасан сонгон шалгаруулалтын ялагчтай бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг тохиролцож, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

26.4.Энэ хуулийн 26.2-т заасан хуулийн этгээдтэй энэ хуулийн 17.5, 17.6-д заасны дагуу бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоно.



## **27 дугаар зүйл.Газрын тосны хэмжилт, үнэ**

27.1.Олборлосон газрын тосны хүргэлтийн цэгийг төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч харилцан тохиролцож тогтооно.

27.2.Хүргэлтийн цэгийн байршлын талаар талууд 30 хоногийн дотор тохиролцож чадаагүй бол төрийн захиргааны байгууллага хүргэлтийн цэгийг тогтооно.

27.3.Хүргэлтийн цэг дээр хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэнэ.

27.4.Төрийн захиргааны байгууллага хяналтын цэгийг тогтоож болно.

27.5.Төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч газрын тосны үнийг олон улсын зах зээл дээр борлуулж байгаа ижил төстэй шинж чанартай газрын тосны үнийг үндэслэн тогтооно.

27.6.Олборлолтын туршилт болон олборлолтын явцад олборлосон газрын тосыг хүргэлт болон хяналтын цэг дээр эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан хэмжих төхөөрөмжөөр хэмжинэ.

27.7.Хэмжих төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан буюу хэмжилт алдаатай хийгдсэн тохиолдолд алдаа гарсан хугацааг хэмжилт алдаатай болсныг мэдсэн өдрөөс өмнө нь хэмжих төхөөрөмжийг хянаж шалгасан өдрийн хоорондох хугацааны дундах өдрөөс эхлэн тооцно.

27.8.Хэмжих төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, байнгын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих зорилгоор мэргэшсэн, хөндлөнгийн байгууллагыг ажиллуулах ба үүнтэй холбогдон гарах зардал, төлбөрийг гэрээлэгч бүрэн хариуцна.

## **28 дугаар зүйл.Газрын тос хадгалах**

28.1.Олборлосон газрын тосыг дараах байдлаар хадгалж болно:

28.1.1.газрын тос хадгалах байгууламж барьж ашиглах;

28.1.2.тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тосны хураагуурын орон зайг төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч ашиглах.

28.2.Энэ хуулийн 28.1.2-т заасан хураагуурт газрын тосыг юүлэх болон буцаан гаргахдаа энэ хууль болон холбогдох дүрэм, журамд заасны дагуу хэмжинэ.





## **29 дүгээр зүйл.Газрын тосыг тээвэрлэх**

29.1.Олборлосон газрын тосыг төмөр зам, тусгай зориулалтын автомашин, эсхүл дамжуулах хоолойгоор тээвэрлэнэ.

29.2.Гэрээлэгч газрын тосыг тусгай зориулалтын автомашинаар тээвэрлэх тохиолдолд холбогдох төрийн захиргааны байгууллагаас баталсан замын төрөл, стандартыг мөрдөнө.

29.3.Гэрээлэгч ашиглалтын талбайд үйлдвэрлэлийн зориулалт бүхий дамжуулах хоолой барьж болох ба уг дамжуулах хоолой нь гэрээний хугацаанд гэрээлэгчийн өмч байх бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болсны дараа энэ хуулийн 39.1-д заасны дагуу шийдвэрлэгдэнэ.

29.4.Гэрээлэгч газрын тосыг борлуулах зориулалт бүхий дамжуулах хоолой барих бол энэ тухай хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

29.5.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 29.4-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш зургаан сарын дотор саналаа Засгийн газарт хүргүүлж, зохих шийдвэр гаргуулна.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨР, ЗАРДАЛ, ӨРТӨГ НӨХӨЛТ, БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ**

### **30 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийн төлбөр, түүнийг хуваарилах**

30.1.Гэрээлэгч газрын тосны хайгуулын болон ашиглалтын үед тусгай зөвшөөрлийн төлбөрийг жил бүр төлнө.

30.2.Хайгуулын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нь гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километр тутамд гурван америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

30.3.Хайгуулын хугацааг сунгасан тохиолдолд тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нэг хавтгай дөрвөлжин километр тутамд найман америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

30.4.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нь нэг хавтгай дөрвөлжин километр тутамд 100 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

30.5.Ашиглалтын хугацааг сунгасан тохиолдолд гэрээт талбайн жилийн төлбөр нэг хавтгай дөрвөлжин километр тутамд 200 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.



30.6.Тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сум, дүүргийн төсөвт, 20 хувийг аймаг, нийслэлийн төсөвт, 70 хувийг улсын төсөвт тус тус хуваарилна.

30.7.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг тухайн санхүүгийн жил эхэлснээс хойш 30 хоногийн дотор төлнө.

30.8.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг энэ хуулийн 30.7-д заасан хугацаанд төлөөгүй бол энэ хуулийн 30.2-30.5-д заасан төлбөрийн гуравны нэгтэй тэнцэх торгуулийг хугацаа хэтрүүлсэн хоног тутамд нэмж тооцон төлнө.

### **31 дүгээр зүйл.Нөөц ашигласны төлбөр, түүнийг хуваарилах**

31.1.Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна.

31.2.Уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь 5-10 хувь байна.

31.3.Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ.

31.4.Засгийн газарт ногдох түүхий тосны жил бүрийн борлуулалтын орлогын гурван хувийг Газрын тосны салбарыг хөгжүүлэх санд төвлөрүүлнэ.

### **32 дугаар зүйл.Өртөг нөхөгдөх зардал, өртөгт газрын тосыг тооцох**

32.1.Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг гэрээлэгч хариуцна.

32.2.Өртөг нөхөгдөх зардлыг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулж, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт газрын тосны хувиар нөхнө.

32.3.Өртөгт газрын тосны хэмжээ нь тухайн жилд олборлосон нийт газрын тосноос нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тосыг хасаад үлдэх тосны 40 хүртэл хувь байх ба уламжлалт бус газрын тосны хувьд энэ хуульд заасан холбогдох журмын дагуу зохицуулна.

32.4.Бүтээгдэхүүн хуваах гэрээ дуусгавар болох үед өртөг нөхөгдөх зардлаас нөхөгдөөгүй үлдсэн хэсгийг гэрээлэгчид олгохгүй.



32.5.Хайгуулын үеийн олборлолтын туршилтын зардал нь хайгуулын ажлын зардалд хамаарна.

32.6.Өртөг нөхөгдөх зардалд энэ хуулийн 30.2-30.5, 30.8, 31.1-31.2, 34 дүгээр зүйлд заасан төлбөр хамаарахгүй.

32.7.Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардал санхүүгийн баримтаар нотлогдоогүй тохиолдолд өртөг нөхөгдөх зардалд тооцогдохгүй.

32.8.Засгийн газар гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардалд хүү төлөхгүй.

### **33 дугаар зүйл.Бүтээгдэхүүн хуваалт**

33.1.Ашигт газрын тосыг Засгийн газар, гэрээлэгчтэй бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хуваана.

33.2.Ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хэмжээг хоногт олборлох газрын тосны хэмжээтэй уялдуулан бүтээгдэхүүн хуваах гэрээнд тодорхойлон заана.

### **34 дүгээр зүйл.Бусад төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлс**

34.1.Гэрээнд гарын үсэг зурсны, олборлолт эхэлсний, олборлолт нэмэгдүүлсний болон сургалтын урамшууллыг энэ хуулийн 17.3-т заасан сонгон шалгаруулалтад захиалагчаас санал болгосон хувь, хэмжээгээр гэрээнд тусгана.

34.2.Гэрээлэгч нь сургалтын болон орон нутаг хөгжүүлэх урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгээс бусад төлбөрийг улсын төсөвт шилжүүлнэ.

34.3.Сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийг төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

34.4.Орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг орон нутгийг хөгжүүлэх санд шилжүүлнэ.

34.5.Хайгуулын талбайн захиалгын үйлчилгээний хөлс 20000 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг төрийн захиргааны байгууллагын дансанд төвлөрүүлнэ.

34.6.Гэрээлэгч хайгуулын талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд 100000 америк доллар, ашиглалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд



250000 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө.

34.7.Гэрээлэгч гэрээний эрх, үүргээ шилжүүлэхдээ хайгуулын талбайд нээлт тогтоогдохоос өмнө 20000 америк доллар, нээлт тогтоогдсоны дараа 50000 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө.

34.8.Ашиглалтын үед гэрээний эрх, үүргээ шилжүүлбэл 100000 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭ ТАЙЛАН, ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

### **35 дугаар зүйл.Мэдээ материал, үр дүнгийн тайлан**

35.1.Гэрээлэгч хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайлан, анхдагч мэдээ материалыг хуанлийн тухайн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

35.2.Гэрээлэгч судалгаа, боловсруулалт, тайлал, лабораторийн туршилт, шинжилгээ хийх зорилгоор чулуун дээж, газрын тос, хий, шингэн болон анхдагч мэдээ материалыг төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч, Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ.

35.3.Гэрээлэгч Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн газрын тос, хий, шингэн, чулуун дээжийн шинжилгээний үр дүн болон чулуун дээж, анхдагч мэдээ материалыг тухайн жилийн ажил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

### **36 дугаар зүйл.Санхүүгийн мэдээ тайлан гаргах**

36.1.Гэрээлэгч нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

36.2.Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн<sup>2</sup> дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана.

<sup>2</sup>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



### **37 дугаар зүйл.Санхүүгийн хяналт шалгалт, баталгаажуулалт**

37.1.Төрийн аудитын байгууллага холбогдох байгууллагатай хамтран гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн тайланд жил бүр хяналт шалгалт хийнэ.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан хяналт шалгалтаар гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг хянан баталгаажуулна.

37.3.Төрийн аудитын байгууллага хараат бус мэргэжлийн хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон шалгаруулж энэ хуулийн 37.1-д заасан санхүүгийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгүүлж болно.

37.4.Гэрээлэгч хяналт шалгалтын ажилд шаардагдах мэдээ, мэдээлэл, тайлан материалыг бүрэн гаргаж өгнө.

### **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **38 дугаар зүйл.Онц байдал, давагдашгүй хүчин зүйл**

38.1.Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт, эсхүл түүний зарим хэсэгт онц байдал зарласан тохиолдолд Засгийн газар гэрээлэгчид ногдох газрын тос, уламжлалт бус газрын тос, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нөхөх олговортойгоор дайчилж болно.

38.2.Монгол Улсад дайны болон дайн бүхий байдал үүссэн тохиолдолд гэрээлэгчийн тухайн үеийн техник, технологи, үйлдвэрлэл явуулах аюулгүй нөхцөлд тохируулан олборлолтыг дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхийг гэрээлэгчээс шаардаж болно.

38.3.Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээлэгчийн үйл ажиллагаа нэг жилээс дээш хугацаагаар саатсан бол төрийн захиргааны төв байгууллага хайгуул, ашиглалтын хугацаан дээр уг хугацааг сунган тооцно.

### **39 дүгээр зүйл.Эд хөрөнгө өмчлөх эрх шилжүүлэх**

39.1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж



ирсэн гэрээлэгчийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материал, үл хөдлөх хөрөнгийг гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө, эсхүл дуусгавар болсны дараа өмчлөх асуудлыг гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.

39.2.Энэ хуулийн 39.1-д заасан хөрөнгийг Засгийн газар шилжүүлэн авахаас татгалзсан тохиолдолд гэрээлэгч нь татан буулгалтыг өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

#### **40 дүгээр зүйл.Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх**

40.1.Гэрээлэгч нь хайгуул, ашиглалтын явцад худаг, өвөлжөө, намаржаа, хаваржаа, хувийн болон нийтийн зориулалттай орон байр, бусад барилга байгууламж, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг бусдын өмчлөл, эзэмшлийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг нь бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

40.2.Гэрээлэгч энэ хуулийн 40.1-д заасан барилга байгууламж, эд хөрөнгийг шилжүүлэн байрлуулахтай холбоотой зардлыг бүрэн хариуцна.

40.3.Энэ хуулийн 40.1-д заасан эд хөрөнгийн хариуцлагыг гэрээлэгч биелүүлээгүй тохиолдолд Иргэний хуулийн<sup>3</sup> дагуу хариуцлага хүлээнэ.

#### **41 дүгээр зүйл.Даатгал**

41.1.Гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, эд хөрөнгө, ашиг сонирхлоо Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын даатгалын эрх бүхий компаниар даатгуулж болно.

41.2.Монгол Улсын даатгалын эрх бүхий компани нь энэ хуулийн 41.1-д заасан даатгалыг хийхээс татгалзсан тохиолдолд гадаад улсын даатгалын хуулийн этгээдээр даатгуулж болно.

#### **42 дугаар зүйл.Бусад ашигт малтмал илрэх, талбай давхцах**

42.1.Хайгуулын явцад байгалийн хийн агууламж илэрсэн тохиолдолд төрийн захиргааны байгууллагад ажлын гурван өдрийн дотор мэдэгдэх бөгөөд тухайн гэрээлэгчтэй байгалийн хийн талаар тусад нь гэрээ байгуулж болно.

<sup>3</sup>Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



42.2.Гэрээлэгч нь хайгуул, ашиглалтын хугацаанд газрын тос, уламжлалт бус газрын тосноос өөр ашигт малтмал илрүүлбэл төрийн захиргааны байгууллагад 15 хоногийн дотор мэдэгдэх бөгөөд уг ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

42.3.Түүхий тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тосны болон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа нь давхацсан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид харилцан гэрээ байгуулж, бие биенийхээ үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр ажиллана.

42.4.Энэ хуулийн 42.3-т зааснаар ажиллах боломжгүй бол уг асуудлыг энэ хуулийн 7.1.10-т заасны дагуу шийдвэрлэнэ.

42.5.Засгийн газар энэ хуулийн 42.4-т зааснаар шийдвэрлэхдээ аль нэг талын үйл ажиллагааг бүрэн зогсооход хүрвэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуул, ашиглалтын үед гарсан бүх зардлыг тусгай зөвшөөрөл авсан тал нь нөхөн төлнө.

#### **43 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх**

43.1.Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад үүсэх эд хөрөнгийн болон бусад маргааныг төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч хэлэлцээрийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

#### **44 дүгээр зүйл.Хариуцлага хүлээлгэх**

44.1.Газрын тосны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд дараах захиргааны шийтгэл ногдуулна:

44.1.1.төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулаагүй этгээд эрлийн ажил хийсэн бол хууль бусаар цуглуулсан судалгааны материал, холбогдох эд зүйлийг хурааж иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

44.1.2.тусгай зөвшөөрөлгүй этгээд газрын тосны хайгуул хийсэн, олборлосон бол хууль бусаар олсон орлого, олборлосон газрын тосыг хурааж тухайн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;



44.1.3.хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулахыг хориглосон буюу хязгаарласан газар нутагт газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулсан бол олсон орлогыг хурааж, тухайн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.4.гэрээлэгч хөрөнгө оруулалт, өмчлөлтэй холбоотой аливаа мэдээллийг Засгийн газрын хүсэлтээр гарган өгөх үүргээ биелүүлээгүй бол тухайн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.5.эрэл, хайгуул, ашиглалтын ажлын тайлан, холбогдох баримт, бичгийн хувийг энэ хуульд заасны дагуу төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх үүргээ зөрчсөн бол тухайн тайлан, баримт бичгийг гаргуулан авч, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.6.хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын туршилтын хугацааг хэтрүүлж олборлолт явуулсан бол олсон орлогыг хурааж, тухайн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.7.тусгай зөвшөөрөл эзэмшигч мэдээ, тайлан, төлөвлөгөөг энэ хууль, журам, гэрээнд заасан хугацаанд гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.8.тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон газрын тосны хэмжээг нуун дарагдуулсан, хөрөнгө оруулалтын зардлыг зохиомлоор өсгөсөн, энэхүү зорилгоор хуурамч гэрээ байгуулсан, эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж, борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан буюу бууруулахыг завдсан бол олборлосон газрын тосны хэмжээ болон үнийн зөрүүг тооцон улсын орлогод нөхөн төлүүлж, тухайн хугацаанд олсон орлогын 50 хувиар торгох;

44.1.9.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дотоодын боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэхээс санаатай зайлсхийсэн бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөн зуугаас дөрвөн зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;





44.1.10.тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахдаа энэ хуулийн 11.2.5-11.2.8, 11.2.12-т заасан үүргээ биелүүлээгүй бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавиас гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.11.хайгуулын ажлын дээж, сорьц, чулуун дээж болон анхдагч материалыг үрэгдүүлсэн, устгасан бол тэдгээрийг нөхөн бүрдүүлж, тухайн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.12.тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр хайгуулын ажлын анхдагч болон үр дүнгийн тайлан, холбогдох материалыг гуравдагч этгээдэд дамжуулсан бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.13.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хууль тогтоомжоор олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан бол иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.14.тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуульд заасан журмын дагуу талбайн хилийн шав тэмдэг тавиагүй, шав тэмдгийг шилжүүлэн байрлуулаагүй бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.15.тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаандаа зөвшөөрөлгүйгээр химийн хорт бодис, бэлдмэл хэрэглэсэн, эсхүл хуулиар хориглосон химийн хорт бодис, бэлдмэл хэрэглэсэн, химийн хорт бодис, бэлдмэлийг хэрэглэхдээ тогтоосон технологийн горим, дүрэм, журмыг дагаж мөрддөггүй бол учирсан хохирол болон хохирлыг арилгахад гарсан зардлыг нөхөн төлүүлж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавиас гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.16.гэрээлэгч нь энэ хуулийн 18.7, 25.7, 25.8-д заасан хугацаанд хөтөлбөр, төсвөө батлуулаагүй бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.



44.1.17.Гэрээнд заасан хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй тохиолдолд хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

44.1.18.Гэрээлэгч нь энэ хуулийн 11.2.9-11.2.11, 11.2.13, 11.2.15, 11.2.17, 11.2.18, 11.2.20-д заасныг зөрчвөл нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

44.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуульд заасан нэг зөрчлийг давтан гаргасан эсхүл энэ хуульд заасан зөрчилд өмнө нь хоёр удаа захиргааны хариуцлага хүлээсэн боловч дахин зөрчил гаргасан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, түүний гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, түүнтэй адилтгах байгууллагын гишүүдийн үүсгэн байгуулсан буюу хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш таван жилийн хугацаанд дахин хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.

44.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Газрын тосны тухай хууль тогтоомж зөрчиж эрүүгийн хариуцлага хүлээсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, түүний гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, түүнтэй адилтгах байгууллагын гишүүдийн үүсгэн байгуулсан буюу хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш таван жилийн хугацаанд дахин хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.

#### **45 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

45.1.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө буюу 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан Газрын тосны тухай хуулийн дагуу байгуулсан гэрээнд энэ хуулийн 17.3.1, 17.3.6-17.3.11, 30.2, 30.4, 32.2, 32.3, 33.1, 33.2-т заасан төлбөр, зардал, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулах ба энэ хуулийн 17.3.2-т заасан нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтооно.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.10.18-15.10.21 дэх заалт нэмсүгэй:

“15.10.18.газрын тос хайх;  
15.10.19.уламжлалт бус газрын тос хайх;  
15.10.20.газрын тос ашиглах;  
15.10.21.уламжлалт бус газрын тос ашиглах.”

**2 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.11-дэх заалтыг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын нөөцийн тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4 дэх заалт нэмсүгэй:

“12.1.4.газрын тосны стратегийн нөөцийг хадгалах хэмжээ, байршлыг тогтоох асуудлаар Засгийн газарт чиглэл өгч захиран зарцуулах эрх нээх.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.3.16, 7.3.17 дахь заалт нэмсүгэй:

“7.3.16.газрын тосны нөөц ашигласны төлбөр;

7.3.17.газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр.”

**2 дугаар зүйл.**Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалтын “хөрөнгө оруулалтын тухай” гэсний дараа “, газрын тосны тухай” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.16, 38.1.17 дахь заалт нэмсүгэй:

“38.1.16.гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан хайгуулын нийт хугацаанд болон ашиглалтын эхний таван жилийн хугацаанд импортолсон тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл;

38.1.17.газрын тос болон уламжлалт бус газрын тостой холбогдсон тайлан материал, дээж болон газрын тос.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.1.25,13.1.26 дахь заалт нэмсүгэй:

“13.1.25.гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан хайгуулын нийт хугацаанд болон ашиглалтын эхний таван жилийн хугацаанд импортолсон тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл;



13.1.26.газрын тос болон уламжлалт бус газрын тостой холбогдсон тайлан материал, дээж болон газрын тос.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

#### **АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “Монгол Улсад байрладаггүй” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

#### **ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.21 дэх заалт нэмсүгэй:

“15.1.21.газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийх;”



**2 дугаар зүйл.**Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.21 дэх заалтын дугаарыг “15.1.22” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/23 дугаар зүйлийн 23.4.11, 23.4.12 дахь заалт:**

“23.4.11.газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 70 хувь;  
23.4.12.газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 70 хувь.”

**2/23 дугаар зүйлийн 23.6.9 дэх заалт:**

“23.6.9.газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20 хувь.”

**3/23 дугаар зүйлийн 23.8.13 дахь заалт:**

“23.8.13.газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувь.”

**4/59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалт:**

“59.1.5. газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.4.35 дахь заалт:**

“5.4.35.Газрын тосны салбарыг хөгжүүлэх сан.”

**2/6 дугаар зүйлийн 6.2.9 дэх заалт:**

“6.2.9.Газрын тосны салбарыг хөгжүүлэх сан.”

**3/25<sup>2</sup> дугаар зүйл:**

**“25<sup>2</sup> дугаар зүйл.Газрын тосны салбарыг хөгжүүлэх сан**

25<sup>2</sup>.1.Энэ хуулийн 5.4.35-д заасан Газрын тосны салбарыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг доор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

25<sup>2</sup>.1.1.газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул хийх;

25<sup>2</sup>.1.2.газрын тос, уламжлалт бус газрын тосны салбарын үндэсний чадавхыг бүрдүүлэх, бэхжүүлэх.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай 35.7, 35.8 дахь хэсэг нэмсүгэй:





“35.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нүүрс олборлох явцад метан хий илрүүлбэл газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

35.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 35.6-д заасан метан хийг ашиглахаар бол Газрын тосны тухай хуульд заасны дагуу ашиглалтын үйл ажиллагаа явуулж болно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/11<sup>1</sup> дүгээр зүйл:**

#### **“11<sup>1</sup> дүгээр зүйл.Үндэсний геологийн албаны чиг үүрэг**

11<sup>1.1</sup>.Монгол Улсын Үндэсний геологийн алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11<sup>1.1.1</sup>.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн зураглал, судалгаа, шинжилгээ хийх;

11<sup>1.1.2</sup>.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх;

11<sup>1.1.3</sup>.геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах, нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх;



11<sup>1</sup>.1.4.ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх.”

### **2/3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг:**

“3.3.Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.”

### **3/34 дүгээр зүйлийн 34.6, 34.7 дахь хэсэг:**

“34.6.Энэ хуулийн 34.2-т заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд тухайн жилд төлөх төлбөрийн үнийн дүнгийн 0.3 хувиар тооцон алданги ногдуулна.

34.7.Энэ хуулийн 34.6-д заасан хугацаа хэтэрсэн хоног 30 хүртэл байх бөгөөд энэ хугацаанаас хэтэрвэл мөн хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцална.”

### **4/35 дугаар зүйлийн 35.9-35.12 дахь хэсэг:**

“35.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгоход тэргүүн ээлжинд стандартын шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээ бүхий Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид давуу эрх олгоно.

35.10.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн гэнэтийн осол, саатал, давагдашгүй хүчин зүйл, шүүхийн шийдвэр, улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг нь зогсоосон болон бусад шалтгаанаар уурхайн бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоохдоо геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.

35.11.Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлнэ.

35.12.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хаяг, цахим шуудан, утас, факсны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд 14 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.”

### **5/48 дугаар зүйлийн 48.12 дахь хэсэг:**

“48.12.Энэ хуулийн 48.3-т заасан хайгуулын үр дүнгийн тайлан болон 48.6.1-д заасан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах,



тэдгээрт хийх хөндлөнгийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг мэргэшсэн мэргэжилтэн, эрх бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.”

**6/56 дугаар зүйлийн 56.8 дахь хэсэг:**

“56.8.Энэ хуулийн 56.1-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцалсан шийдвэрийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тусгай зөвшөөрлийн хугацааг үргэлжлүүлэн тооцно.”

**7/4 дүгээр зүйлийн 4.1.24-4.1.26 дахь заалт:**

“4.1.24. “ашигт малтмалын баялаг” гэж геологийн зураглал, сэдэвчилсэн судалгаа, эрэл, хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн, эдийн засгийн ач холбогдол нь нарийвчлан үнэлэгдээгүй эрдсийн хуримтлалын хэсгийг;

4.1.25. “ашигт малтмалын ордын нөөц” гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эдийн засгийн үр ашигтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсгийг;

4.1.26. “мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч” гэж үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагаас эрх олгогдсон иргэнийг.”

**8/9 дүгээр зүйлийн 9.1.9-9.1.13 дахь заалт:**

“9.1.9. Үндэсний геологийн алба байгуулах;

9.1.10. энэ хуулийн 42.1-д заасан гэрээний загварыг батлах;

9.1.11. геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх;

9.1.12. стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагийг тогтоох;

9.1.13. ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлэн авч нөхөх олговрын



асуудлыг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр энэ хуулийн 19.12, 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгож болно.”

**9/10 дугаар зүйлийн 10.1.11-10.1.18 дахь заалт:**

“10.1.11.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмыг батлах;

10.1.12.баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах;

10.1.13.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий төрийн байгууллага, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагын төлөөллийн тэгш байдлыг хангасан орон тооны бус бодлогын зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг батлах;

10.1.14.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

10.1.15.геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг батлах;

10.1.16.геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах;

10.1.17.ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг батлах;

10.1.18.үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагатай хамтран ашигт малтмалын баялаг, ордын нөөц, хайгуулын ажлын үр дүнг нийтэд нээлттэй тайлагнах журмыг батлах.”

**10/11 дүгээр зүйлийн 11.1.24, 11.1.25 дахь заалт:**

“11.1.24.хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргасан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн мэдээллийн бүртгэл хөтлөх;

11.1.25.ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг солбицлоор тодорхойлох.”

**11/14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэг:**

“14.9.Энэ хуулийн 13.5, 14.8-д заасны дагуу чөлөөлөгдсөн талбайг урьд нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж байсан этгээдэд үргэлжлүүлэн эзэмшүүлэхдээ тусгай зөвшөөрлийн хугацааг тусгай хэрэгцээ, нөөцөд байсан хугацаагаар сунгаж тооцно.”

**12/27 дугаар зүйлийн 27.1.12, 27.1.13 дахь заалт:**

“27.1.12.энэ хуулийн 48.6.1-д заасан тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгасан байх;

27.1.13.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын асуудлаар тогтмол мэдээлэх үүрэг бүхий ажилтантай байх;”

**13/33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалт:**

“33.1.4.тусгай зөвшөөрлийн 10-12 дахь жилд 10 америк доллар.”

**2 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтын “нэмэгдүүлэх” гэсний дараа “баяжуулах,” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “хамааруулах” гэсний дараа “, хасах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “хамааруулах” гэсний дараа “, хасах” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтын “зохион явуулах” гэсний дараа “, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах” гэж, 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтын “факсны дугаар” гэсний дараа “, цахим шуудангийн хаяг” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын “факсны дугаар” гэсний дараа “цахим шуудангийн хаяг,” гэж, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “1,5 америк доллар” гэсний дараа “, 10-12 дахь жилд 5 америк доллар” гэж, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “эзэмшигч” гэсний дараа “болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч” гэж, 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтын “30 хоногийн” гэсний дараа “, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны” гэж, 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь заалтын “төлбөрийг” гэсний дараа “энэ хуулийн 34.7-д заасан” гэж, мөн зүйлийн 56.7 дахь хэсгийн “татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “болон мэргэжлийн хяналтын” гэж, 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийн “эсхүл” гэсний дараа “захиргааны хэргийн” гэж тус тус нэмсүгэй.



**3 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:**

“7.3.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг ердийн ашигт малтмалын адил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.”

**2/20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг:**

“20.1.Энэ хуулийн 53.1.1, 56.1.3-56.1.5-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл нь дуусгавар болсон, цуцлагдсан бол төрийн захиргааны байгууллага доор дурдсан журмын дагуу сонгон шалгаруулалт явуулж тусгай зөвшөөрлийг шинээр олгоно.”

**3/45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг:**

“45.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол төрийн захиргааны төв байгууллагад нэгээс доошгүй жилийн өмнө мэдэгдэж, энэ хуулийн 10.1.14-д заасан журмын дагуу зохих бэлтгэлийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:”

**4/48 дугаар зүйлийн 48.3, 48.4 дэх хэсэг:**

“48.3.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланг ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагааны журам, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалд нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

48.4.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник, эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.”

**5/4 дүгээр зүйлийн 4.1.12, 4.1.23 дахь заалт:**

“4.1.12.”стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн



хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг;”

“4.1.23.“бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл ордын талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг;”

#### **6/10 дугаар зүйлийн 10.1.5, 10.1.9 дэх заалт:**

“10.1.5.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх жил бүрийн геологийн судалгааны ажлын төлөвлөгөө, төсөл, төсвийг батлах, тодотгох, үр дүнгийн тайланг хүлээн авсан тухай шийдвэр гаргах;”

“10.1.9.Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн гишүүдтэй Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлалыг батлах;”

#### **7/48 дугаар зүйлийн 48.1.2, 48.6.1- 48.6.3 дахь заалт:**

“48.1.2.хайгуулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;”

“48.6.1.тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор;

48.6.2.дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд, уулын ажлын төлөвлөгөөг батлагдсан зааврын дагуу 12 дугаар сарын 01-ний дотор;

48.6.3.ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн зэрэглэлийг ахиулах ашиглалтын хайгуулыг тухай бүр хийж, ажлын төлөвлөгөө, тухайн жилийн болон хайгуулын ажлын үр дүнгийн тайланг энэ хуулийн 48.1.2-т заасны дагуу.”

**8/66 дугаар зүйлийн 66.1.2 дахь заалт:**

“66.1.2.энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан мэдээ, төлөвлөгөө, ашиглалтын үйл ажиллагааны тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;”

**4 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “олговор” гэснийг “олговрыг нэг жилийн дотор” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Тусгай хэрэгцээ болон нөөцөд аваагүй” гэснийг “Монгол Улсын” гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “400 мянган” гэснийг “150 мянган” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “2” гэснийг “3” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтын “уурхайн эдэлбэрээс олборлосон” гэснийг “ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий хуулийн этгээд” гэж, 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн “5” гэснийг “10” гэж, 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалтын “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.3 дахь заалтын “100000-300000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “1000000-2000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.4 дэх заалтын “100000-500000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.5 дахь заалтын “200000-500000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.6 дахь заалтын “100000-250000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “1000000-2000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.7 дахь заалтын “1000000-250000” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.8 дахь заалтын “200000-500000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний





доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.9 дэх заалтын “100000-300000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “1000000-2000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.2 дахь хэсгийн “200000-300000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Хууль хүчин төгөлдөр болох

6.1.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

6.2.Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө тухайн үед мөрдөж байсан хууль тогтоомжийн дагуу байгуулсан ашиглалтын өмнөх гэрээг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын хугацаанд уг хуульд заасан журмын дагуу шинэчлэн бүртгэж, гэрээний хугацаанд хүчинтэйд тооцож тухайн үед мөрдөж байсан хуулийн дагуу төлбөр төлнө.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ  
ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2012 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “газар,” гэсний дараа “эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхаргазүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.1.24 дэх заалт нэмсүгэй:

“13.1.24.нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин, зөөврийн компьютерийн хувьд гуч дахин нэмэгдүүлснээс тус тус дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.15 дахь заалт нэмсүгэй:

“38.1.15.нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид “шилэн данс” гэх/-г бүрдүүлэхэд оршино.

##### 2 дугаар зүйл.Шилэн дансны тухай хууль тогтоомж

2.1.Шилэн дансны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Төсвийн тухай хууль<sup>2</sup>, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль<sup>3</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль<sup>4</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;

3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 26 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2005 оны 48 дугаарт нийтлэгдсэн.



3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.

3.2.Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна:

3.2.1.улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сан, Хүний хөгжил сангийн төсөв;

3.2.2.орон нутгийн хөгжлийн сан;

3.2.3.Засгийн газрын тусгай сан;

3.2.4.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа;

3.2.5.Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл;

3.2.6.Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж;

3.2.7.төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс;

3.2.8.Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр.

3.3.Төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ хуульд хамаарахгүй.

3.4.Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно.

#### **4 дүгээр зүйл.Шилэн дансны зарчим**

4.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;

4.1.2.мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;



4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;

4.1.4.хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ШИЛЭН ДАНСНЫ СТАНДАРТ**

### **5 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэр**

5.1. Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1. шилэн дансны бие даасан цэстэй байх;

5.1.2. мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх;

5.1.3. тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх;

5.1.4. мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх.

5.2. Шилэн дансны мэдээллийг дуу болон дүрс бичлэгийн хэлбэрээр байрлуулж болно.

5.3. Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шилэн дансны нэгдсэн цахим хуудастай байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас ажиллуулж эхлэх хугацааг энэ хуулийн хэрэгжилтийн байдлыг харгалзан Засгийн газар 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө байхаар тогтоох бөгөөд уг нэгдсэн цахим хуудсыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө.

5.4. Энэ хуулийн 5.1, 5.3-т заасан цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

5.5. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна.

5.6. Энэ хуулийн 3.2.5-3.2.8-д заасан шийдвэр энэ хуулийн 5.3-т заасан хугацаанаас хойш шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршсанаар хүчин төгөлдөр болно.



5.7.Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна.

5.8.Мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

### **6 дугаар зүйл.Шилэн дансны мэдээлэл**

6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;

6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

6.1.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.

6.2.Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:

6.2.1.эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт;



6.2.2.орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/;

6.2.3.урсгал зардал /цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, хөрөнгийн зардал, татаас шилжүүлэг/;

6.2.4.хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт;

6.2.5.улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа;

6.2.6.зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/.

6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:

6.3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт;

6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт;

6.3.3.төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар;

6.3.4.өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх;

6.3.5.хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт;

6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл;

6.3.7.хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр;

6.3.8.тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт;

6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.





6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;

6.4.2.тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;

6.4.3.тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

6.4.6.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;

6.4.7.байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;

6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

6.4.9.хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

6.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана:

6.5.1.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг хагас жилийн байдлаар тухайн жилийн 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;



6.5.2.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг улирал бүр;

6.5.3.Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээллийг улирал бүр;

6.5.4.улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр;

6.5.5.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 15-ны өдрийн дотор;

6.5.6.төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа жилийн 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор;

6.5.7.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээллийг улирал бүр.

6.6.Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана:

6.6.1.концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш долоо хоногийн дотор;

6.6.2.концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор;

6.6.3.концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор;

6.6.4.хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээллийг улирал бүр;

6.6.5.улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлтүүдтэй уялдуулсан судалгаа, тооцоог улирал бүр.

6.7.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчилж мэдээлнэ.



6.8.Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

6.8.1.тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр;

6.8.2.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

6.8.3.төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт.

6.9.Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.

6.10.Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн<sup>5</sup> 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.

## **7 дугаар зүйл.Мэдээлэх албан тушаалтан**

7.1.Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ:

<sup>5</sup>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн.



7.1.1.Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан;

7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан эрх бүхий албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн албан тушаалтан;

7.1.3.тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ШИЛЭН ДАНСНЫ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

### **8 дугаар зүйл.Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт**

8.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

8.2.Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

8.3.Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж болно.

8.4.Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.

### **9 дүгээр зүйл.Иргэний хяналт**

9.1.Энэ хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл,



гомдлыг шийдвэрлэх тухай хуульд<sup>6</sup> заасан журмын дагуу төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно.

9.2.Төрийн аудитын байгууллага нь гомдол, мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тухайн иргэнд бичгээр болон олон нийтэд мэдээлнэ.

9.3.Иргэн, хуулийн этгээдийн татвар төлөгчийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

### **10 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

10.1.Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн<sup>7</sup> 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

10.2.Энэ хуулийн 3.1.1-д зааснаас бусад энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын албан тушаалтан шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөнийг шүүх, эрх бүхий улсын байцаагч тогтоосон бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.3.Энэ хуулийн 10.2-т заасан байгууллагыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэж шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

10.4.Энэ хуулийн 5.4-т заасан журам батлагдаагүй нь байгууллага, албан тушаалтан энэ хуулийг хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

### **11 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

11.1.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

<sup>6</sup>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup>Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### 1/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:

“9.1.Энэ хуулийн 3.1-д заасан байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдалтай холбогдсон харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна.”

#### 2/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг:

“10.1.Энэ хуулийн 3.1-д заасан байгууллагын төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдалтай холбогдсон харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсэг, 9.1.1-9.1.6 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.1-10.1.8 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Шилэн дансны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.5 дахь хэсгийг нэмсүгэй:



**1/40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэг:**

“40.5.Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 40.1-д заасан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харгалзана.”

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, 8.9.4 дэх заалтын “ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх” гэснийг, 8.8.5, 8.10.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Шилэн дансны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийн “тэдгээрт” гэсний дараа “болон хуульд” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шилэн дансны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН  
АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1



дэх хэсгийн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,” гэсний дараа “Шилэн дансны тухай хууль,” гэж, 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” гэсний дараа “хууль, Шилэн дансны тухай” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шилэн дансны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар  
хот

### **Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Октябрийн Баасанхүү, Дашдондогийн Ганбат, Раднаасүмбэрэлийн Гончигдорж нарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Агыпарын Бакей, Лувсанвандангийн Болд, Мөнхчулууны Зоригт, Дондогдоржийн Эрдэнэбат нарыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Отгонбилэгийн Содбилэг, Долгосүрэнгийн Сумъяабазар нарыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн Баярсайхан, Баярбаатарын Болор, Данзангийн Лүндээжанцан, Нямтайширын Номтойбаяр, Чимэдийн Хүрэлбаатар нарыг Өргөдлийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Жалбасүрэнгийн Батзандан, Батхүүгийн Гарамгайбаатар, Батсүхийн Наранхүү, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарыг Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Ядамсүрэнгийн Санжмятав, Цэрэндашийн Цолмон нарыг Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Догсомын Батцогт, Сангажавын Баярцогт нарыг Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Догсомын Батцогт, Дэндэвийн Тэрбишдагва нарыг Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.





2.Улсын Их Хурлын гишүүн Лувсанвандангийн Болд, Ёндонгийн Отгонбаяр, Цэрэндашийн Цолмон нарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулга, Отгонбилэгийн Содбилэг, Дэндэвийн Тэрбишдагва, Жаргалтулгын Эрдэнэбат нарыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Цэдэвдамбын Оюунгэрэл, Дамдингийн Хаянхярваа нарыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Октябрийн Баасанхүүг Өргөдлийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Дашдорж, Данзангийн Лүндээжанцан, Чимэдийн Хүрэлбаатар, Нямаагийн Энхболд нарыг Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Долгорсүрэнгийн Сумъяабазар, Дуламсүрэнгийн Оюунхорол нарыг Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Нямтайширын Номтойбаяр, Цэндийн Нямдорж нарыг Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Жамъянсүрэнгийн Батсуурь, Өлзийсайханы Энхтүвшин нарыг Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 4,010,398.6 сая /дөрвөн их наяд арван тэрбум гурван зуун ерэн найман сая зургаан зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

2.Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 4,683,038.2 сая /дөрвөн их наяд зургаан зуун наян гурван тэрбум гучин найман сая хоёр зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 47

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэл  
баталсантай холбогдуулан авах зарим  
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэг, 36<sup>1</sup> дүгээр зүйлийн 36<sup>1.1</sup> дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

1/эдийн засгийн хямрал нийгэмд бодитойгоор нөлөөлж, төсвийн орлого бүрдүүлэлт их хэмжээгээр тасалдах болсонтой холбогдуулан Засгийн газар хэмнэлтийн горимд шилжин, илүү шат дамжлагыг цөөлөх, тэвчиж болох урсгал зардлыг танах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох санал боловсруулж Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх;

2/үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд улсын төсвийн хөрөнгийг оновчтой зарцуулах зорилгоор Засгийн газрын тусгай сангууд, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, ашиглалтад тавих хяналтыг сайжруулах;

3/Монгол Улсын нэгдсэн төсвөөс гадуур хяналтгүй зарцуулагдаж байгаа “Чингис” болон “Самурай” бондын зарцуулалтыг төсөвт тусгах арга хэмжээг авах;

4/Төрийн сангийн гадуур нээсэн төсвийн дансны гүйлгээнд шалгалт хийж зөрчлийг арилгах, эдгээр дансыг хааж, хөрөнгийн үлдэгдлийг Төрийн санд төвлөрүүлэх арга хэмжээ авч, дүнг Улсын Их Хуралд 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулах;

5/Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн Үндэсний аудитын газрын зөвлөмж, санал дүгнэлтэд тусгагдсан, улсын төсвийн орлогын төлөвлөгөөг тасалдуулсан, батлагдсан төсөв, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан бүх шатны төсвийн захирагчдад төсвийн тухай хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, дүнг 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;



6/Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, төсөв хэтрүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулах явдлыг таслан зогсоох, үүссэн өр, авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт Улсын Их Хуралд хэлэлцүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд, уг тогтоолын хэрэгжилтийн явцыг Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хот

#### **Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн төсөл;

2/Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн төсөл;

3/Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн төсөл;

4/Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/Худалдааны тухай хуулийн төсөл;

6/Татварын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон шинэчилсэн найруулгын төсөл;



7/Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төсөл;

8/Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

9/Гэмт хэргийн тухай хуулийн төсөл;

10/Зөрчлийн тухай хуулийн төсөл;

11/Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

12/Монгол хэлний тухай хуулийн төсөл;

13/Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

14/Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

15/Хяналтын тухай хуулийн төсөл;

16/Монгол Улсын сонгуулийн нэгдсэн хуулийн төсөл;

17/Улс төрийн намын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

18/Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

19/Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

20/бусад.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэж байхаар тогтоосугай.



3.Монгол Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангахыг Монгол Улсын Засгийн газар /Н. Алтанхуяг/, Байнгын хороод, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт  
оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд Газрын тосны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тухайн асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

**Байнгын хорооны даргыг  
чөлөөлөх тухай**

Санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар томилогдсон тул өөрийн хүсэлтээр нь Улсын Их Хурлын гишүүн



Шаравдоржийн Түвдэндоржийг Хууль зүйн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 51

Улаанбаатар  
хот

**Байнгын хорооны даргыг  
сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатыг сонгосугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 52

Улаанбаатар  
хот

**Тусгай хяналтын дэд хорооны  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Цолмонг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг хавсралтаар баталсугай.

2."Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3."Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, түүний биелэлтийн явцыг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



Монгол Улсын Их Хурлын 2014 оны  
53 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2015 онд хүрэх түвшин, үр дүн	2015 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7

**НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

**Зорилт 1. Эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх бодлого баримтална.**

1.1	Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого /цаашид "ҮХЦБ" гэх/	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогыг хэрэгжүүлэх	Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид "ДНБ" гэх/-ий бодит өсөлт, хувь	10 хувиас доошгүй	-	Эдийн засгийн хөгжлийн яам /цаашид "ЭЗХЯ" гэх/, холбогдох яамд
				5000 ам.доллар-оос дээш	-	
1.2	"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" /цаашид "ЗҮҮАХХАХТ" гэх/-ий 5.8, 5.9, 12.1 дэх заалт	Эдийн засгийн болон мөнгөний бодлогоор дамжуулан инфляцийг нэг оронтой тоонд байлгаж, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг бууруулах	Жилийн эцсийн инфляцийн зорилтот түвшин	1 оронтой тоонд байлгах	-	Монголбанк



**Зорилт 2.Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.**

2.1	ЗГҮАХХАХТ-ний 147.1 дэх заалт	Ажлын байр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын тусгай сангуудыг нэгтгэх хууль эрх зүйн орчин бий болгох	Ажилгүйдлийн түвшин, хувь	6.6 хувь	Хөдөлмөрийн яам /цаашид "ХЯ" гэх/,ЭЗХЯ
2.2	ҮХЦБ-ын 4.8, "Ажилтай, орлоготой Монгол хүн" Үндэсний хөтөлбөрийн 3.3 дахь заалт	Эдийн засгийн салбаруудын ажиллах хүчний төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах	Ажиллах хүчний хэтийн тооцооллыг хэрэгжүүлэх салбарын тоо	4-өөс доошгүй салбар	Уул уурхайн яам /цаашид "УУЯ" гэх/, Соёл, спорт, аялал жуулчлалын яам /цаашид "ССАЖЯ" гэх/, Зам тээврийн яам /цаашид "ЗТЯ" гэх/, Эрүүл мэндийн яам /цаашид "ЭМЯ" гэх/



Зорилт 3.Төсвийн тогтвортой, тэнцвэрт байдлыг хангах бодлого баримтлахын зэрэгцээ, санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.						
3.1	ЗГУАХХАХТ-ний 11.1, 13.1, 13.2, 14.1 дэх заалт	Төсвийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлж, төсвийн зохистой харьцааг хадгалах	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэрбум төгрөг	7201.1	-	Сангийн яам /цаашид "СЯ" гэх/, ЭЗХЯ
				7690.9		
3.2	ЗГУАХХАХТ-ний 25.2 дахь заалт	Гадаад улс орнуудтай байгуулсан давхар татварын гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгох	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөг	-489.8	-	СЯ
				100 хувь		
3.3	УХЦБ-ын 7.2 дэхь заалт, ЗГУАХХАХТ-ний 17.3, 17.4, 27.1 дэх заалт	Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох	Засгийн газрын нийт худалдан авалтад цахим худалдан авалтын эзлэх хувь	50 хувь	-	СЯ, Шадар сайдын ажлын алба

3.4	ЗГҮАХХАХТ-ний 2.1, 2.2, 2.3 дахь заалт	Зээлийн хүү бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Шинэчлэх хуулийн тоо	1	-	Монголбанк, ЭЗХЯ, СЯ
<b>Зорилт 4.Гадаад худалдааны бодлогоор дамжуулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтална.</b>						
4.1	ЗГҮАХХАХТ-ний 41.1 дэх заалт	Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, эрдэс баялгийн экспортыг нэгдсэн "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх	Нэг цонхны бодлого хэрэгжих ажлын явц, хувь	100 хувь	-	УУЯ, ЭЗХЯ
4.2	ЗГҮАХХАХТ-ний 61.1, 61.2 дахь заалт	Дөлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргийн дагуу гааль, тарифын механизмыг ашиглан үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлого баримтлах	Импортын зарим бараанд нэр төрөл, бус нутаг, үйлдвэрлэгчээр нь ялгавартай ногдуулах тарифын хувь	20 хүртэл хувь	-	СЯ, ЭЗХЯ



**ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО**

**Зорилт 5.Уламжлалт мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.**

5.1	ЗГҮАХХАХТ-ний 31.1 дэх заалт	“Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг шинэчилж, салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх	Бодлогыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам /цаашид УХААЯ гэх/
5.2	ЗГҮАХХАХТ-ний 75.1, 75.2, 75.3, 75.4 дэх заалт	Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувууны аж ахуй эрхэлж байгаа аж ахуйг дэмжих зээлийн санг 50.0 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх	Импортын сүүг орлуулах хэмжээ, хувь	30 хувь	50.0 Улсын төсөв	УХААЯ, СЯ, ЭЗХЯ
			Импортын гахайн махыг орлуулах хэмжээ, хувь	25 хувь		
			Өндөгний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах хэмжээ, хувь	70 хувь		
5.3	ЗГҮАХХАХТ-ний 77.1, 77.4 дэх заалт	Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах	Бэлтгэх нөөцийн махны хэмжээ, мян.тонн	14.0	14.0 Улсын төсөв	УХААЯ, СЯ, ЭЗХЯ

5.4	ЗГҮАХХАХТ-ний 69.2, 69.3 дахь заалт	Малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг дотооддоо боловсруулах	Боловсруулах ноолуурын хувь	20-оос дээш хувь	120.0 Бусад эх үүсвэр	УХАААЯ
			Боловсруулах ноосны хувь	50-аас дээш хувь		
			Боловсруулах арьс ширний хувь	15 дээш хувь		
<b>Зорилт 6.Эдийн засгийн өсөлтийг дэмжих эрчим хүчний салбарын бодлогыг хэрэгжүүлнэ.</b>						
6.1	ЗГҮАХХАХТ-ний 64.1, 65.1, 67.2, 67.3, Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр /цаашид "МУЭХНСХ" гэх/-ийн 4.1.2, 4.1.3, 4.1.19 дэх заалт	Уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр бүс нутаг дахь эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангах	Эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	80 хувь	200.0 Гадаад, дотоод эх үүсвэр	Эрчим хүчний яам /цаашид "ЭХЯ" гэх/
6.2	ЗГҮАХХАХТ-ний 56.1, 56.2, 67.11, 67.12 дахь заалт, "Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр"-ийн 4.1.2, 4.2.4 дэх заалт	Цахилгаан дамжуулах сүлжээний 220 кВТ, түүнээс дээш өндөр хүчдэлийн шугамыг байгуулах	Шугамын барилга угсралтын ажлын явц, хувь	30 хувь	100.0 Концесс	ЭХЯ



6.3	ЗГҮАХХАХТ-ний 225 дахь хэсэг	Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын усан цахилгаан станцыг барьж байгуулах бэлтгэлийг хангах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, төслийн нэгж ажиллуулах	-	-	-	ЭХЯ
<b>Зорилт 7.Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулна.</b>						
7.1	ЗГҮАХХАХТ-ний 79.2, 79.4, 79.5, 86.1, 86.2 дахь заалт	"Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлэх	Хөтөлбөр боловсруулах ажлын явц, хувь	100 хувь	-	ССАЖЯ, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам /цаашид "БОНХЯ" гэх/, ЭЗХЯ
7.2	ҮХЦБ-ын 5.2.1.5 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 81, 83 дахь заалт	Аялал жуулчлалыг бүс нутгийн онцлолт тулгуурлаж төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	-	ССАЖЯ, Берилга, хот байгуулалтын яам /цаашид БХБЯ гэх/



**Зорилт 8.Тээврийн салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд эдийн засгийн өндөр өсөлтийг дэмжсэн, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэл баримтална.**

8.1	"ҮХЦБ"-ын 5.3.1-4, "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого" /цаашид "ТТЗТТББ" гэх/-ын 3.2.2, ЗГҮАХХАХТ-ний 107.1 дэх заалт	1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх	Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн 225 км	100 хувь	Төсвийн бус эх үүсвэр, концесс	ЭЗХЯ, ЗТЯ
			Ухаа худаг-Сайншанд чиглэлийн 435 км	30 хүртэл хувь		
			Сайншанд-Баруун Урт-Хөөт чиглэлийн 430км	30 хүртэл хувь		
			Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 415 км	30 хүртэл хувь		
			Хөөт-Нөмрөг чиглэлийн 380 км	10 хүртэл хувь		
			Могойн гол – Эрдэнэт 500 км	20 хүртэл хувь		
			Сайншанд-Замын-Үүд 235 км	20 хүртэл хувь		



8.2	ҮХЦБ-ын 5.3.1.4 дэх заалт	Мандал – Зуунмод – Багахангай чиглэлд Улаанбаатар хотыг тойруулан төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх	Суурь бүтэц барих ажлын явц, хувь	30 хүртэл хувь	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	ЗТЯ
8.3	ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь заалт	Аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх	Ашиглалтад оруулах авто замын урт	1400 км	Концесс	ЭЗХЯ
8.4	ЗГҮАХХАХТ-ний 111.1 дэх заалт	Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүдийн хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Барилгын ажлын замын урт	1200 км	Концесс	ЭЗХЯ
8.5	ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь заалт	Бичиг–Баруун-Урт чиглэлийн авто замыг барьж ашиглалтад оруулах	Ашиглалтад оруулах авто замын урт	267 км	Концесс	ЭЗХЯ
8.6	“Транзит Монгол” Үндэсний хөтөлбөрийн 5.2.5 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 119.3 дахь заалт.	Замын-Үүд суманд холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах	Ажлын явц, хувь	90 хувь	42.5 Улсын төсөв, 8.0 АХБ-ны Тусламж, 64.0 АХБ-ны зээл	ЗТЯ



8.7	ЗГҮАХХАХТ-ний 84.3 дахь заалт	Европын холбооны улсын нутаг дэвсгэрт агаарын тээвэрлэлтийн 5 дугаар эрх авах зохицуулалтыг бүрдүүлж, шинээр Сингапур, БНЗУ руу хуваарьт нислэг гүйцэтгэх	Шинээр нислэг үйлдэх чиглэлийн тоо	2 чиглэл	-	ЗТЯ
8.8	ЗГҮАХХАХТ-ний 220.3 дахь заалт, ШББДХЗХ-ийн 4.4.5.26 дахь заалт	Нийтийн тээврийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх	Шинээр үйлдвэрлэх цахилгаан тээврийн хэрэгслийн тоо	10	2.0 Улсын төсөв	ЗТЯ, Нийслэлийн засаг даргын Тамгын газар /цаашид НЗДТГ гэх/
<b>Зорилт 9. Уул уурхайн салбарыг дэмжих чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.</b>						
9.1	ЗГҮАХХАХТ-ний 50.1 дэх заалт	Дархан-Сэлэнгийн бүсэд металлургийн цогцолбор байгуулах бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	Концесс	ЭЗХЯ, УХААЯ
9.2	ЗГҮАХХАХТ-ний 7 дахь заалт	Экспортын нэг цонхны бодлогыг хэрэгжүүлж, эрдэс баялгийн биржийн эрх зүйн орчныг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100 хувь	0.2 Улсын төсөв	УУЯ



9.3	УХЦБ-ын 5.2.1.1, ЗГҮАХХАХТ-ний 38 дахь заалт	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийж гүйцэтгэх	Нийт хамруулах газар нутгийн хэмжээ, хувь	36 хувь	15.0 Улсын төсөв	УУЯ
9.4	ЗГҮАХХАХТ-ний 99 дэх заалт, Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого 3.3.2 дахь заалт	Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж эхлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Үйлдвэрийн барилгын ажил эхэлсэн байна.	Хувийн хөрөнгөөр	УУЯ
9.5	УХЦБ-ын 5.2.1.1 дэх заалт	Нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтын үйлдвэрийг ажиллуулж эхлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Туршилтын үйлдвэр ашиглалтад орсон байна.	Зээлийн хөрөнгөөр	УУЯ

**Зорилт 10.Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.**

10.1	ЗГУАХХАХТ-ний 304.1 дэх заалт	Эрдэм шинжилгээний туршилтын баазыг бэхжүүлж, төрөлжсөн эрдэм шинжилгээний лаборатори, туршилт-үйлдвэрлэлийн төвийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинээр байгуулах	Шинээр байгуулах төрөлжсөн лабораторийн тоо  Шинээр байгуулах туршилт, үйлдвэрлэлийн төвийн тоо	1  1	12.0 Улсын төсөв  10.0 Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны яам /цаашид БШУЯ гэх/	БШУЯ
10.2	ҮХЦБ-ын 5.3.4 дэх заалт, ЗГУАХХАХТ-ний 38.2 дахь заалт	Өндөр нарийвчлал бүхий тандан судалгааны хиймэл дагуул хөөргөх төслийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Хиймэл дагуулын техникийн шийдлийг боловсруулж, үйлдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн байна.	50.0 Гадаад эх үүсвэр	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар /цаашид МТШХХГ гэх/	
10.3	ЗГУАХХАХТ-ний 141.4 дэх заалт	Шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг өргөн зурвасын сүлжээнд холбох	Шилэн кабельд холбогдох сумын тоо	16	9.6 Улсын төсөв, бусад эх үүсвэр	МТШХХГ	



ГУРАВ БУС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО						
Зорилт 11. Хүн амын нутагшилт, суурьшил, бус нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот, сууринг хөгжүүлж, газар ашиглалтыг сайжруулна.						
11.1	ҮХЦБ-ын 5.3.5.1, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 2.3.5, 4.7.5.а, ЗГҮАХХАХТ-ний 106.3 дахь заалт	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл"-ийг боловсруулах	Ажлын явц, хувь	70 хувь	3.0 Улсын төсөв	БХБЯ, холбогдох яамд
11.2	ҮХЦБ-ын 5.3.5.4, ЗГҮАХХАХТ-ний 130.2 дахь заалт	Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан багалгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувь	100 хувь	2.0 Улсын төсөв	БХБЯ, аймаг, нийслэлийн ЗДТ
11.3.	ҮХЦБ-ын 5.3.5.4, ЗГҮАХХАХТ-ний 222.4, 222.5 дахь заалт	Газрын бирж байгуулах ажлыг зохион байгуулах ажлыг эхлүүлэх	Бирж байгуулах ажлын явц, хувь	50 хүртэл хувь	2.5 Улсын төсөв	БХБЯ, СЯ, Хууль зүйн яам Цаашид ХЗЯ гэх/
Зорилт 12. Хүн амын орон сууцны хангамж, дэд бүтцийг сайжруулж, хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлнэ.						
12.1	Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол	"Сумдын хөгжлийн загвар"-ын хүрээнд үйлдвэр, технологийн парк, технологи дамжуулах төв бий болгох ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	10 хувь	2.0 Гадаад эх үүсвэр	УХААЯ, ЭЗХЯ

12.2	<p>ҮХЦБ-ын 5.3.5.1, ШББДХЗХ-ийн 4.4.6.2, ЗГҮАХХАХТ-ний 141.1 дэх заалт</p>	<p>"Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр"-ийн хүрээнд сумын төвүүдэд ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлыг эхлүүлэх</p>	<p>Хөтөлбөрт хамрагдах сумын тоо</p>	20	<p>100.0 Улсын төсөв болон бусад эх үүсвэр</p>	<p>БХБЯ, ЭЗХЯ</p>	
12.3	<p>ЗГҮАХХАХТ-ний 8 дахь заалт</p>	<p>Улс, бүс нутгийн онцгой ач холбогдол бүхий боомтуудын үндсэн дэд бүтэц, барилга, байгууламжийг цогцоор нь барьж байгуулах</p>	<p>Үндсэн дэд бүтэц, барилга байгууламж барих боомтын тоо</p>	6	<p>40.0 Улсын төсөв, Коңцесс, Гадаадын хөрөнгө оруулалт</p>	<p>БХБЯ, ЭЗХЯ, Боомтын нэгдсэн захиргаа</p>	
<p><b>Зорилт 13. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохиистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.</b></p>							
13.1	<p>ҮХЦБ-ын Стратегийн зорилт 1-ийн 6 дугаар заалт</p>	<p>Агаарын бохирдлыг бууруулах урамшууллын арга хэмжээг үргэлжлүүлж, агаарын чанарыг сайжруулах ажлыг хэрэгжүүлэх</p>	<p>Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамрагдаж урамшуулал авах айл өрх</p>	71.0 мянга	<p>5.0 Улсын төсөв</p>	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яам /цаашид "БОНХЯ" гэх/, УУЯ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид "НЗД" гэх/</p>	

13.2	ЗГҮАХХАХТ-ний 233.2, 233.5 дахь заалт	Ойн экосистемийг хамгаалах шинэ технологийг нэвтрүүлэх, ойжуулалтын үр дүнг сайжруулах	Шинэ технологоор тэмцэл хийх талбайн хэмжээ	90 мян.га	8.0 Улсын төсөв	БОНХЯ
13.3	ЗГҮАХХУАТ 226, Ус үндэсний хөтөлбөр. 3.2, 3.3, 3.4	Гидрогеологийн зураглал, региональ судалгаа, ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуул судалгаа хийх	Ойжуулах талбайн хэмжээ	8.5 мян.га	3.2 Улсын төсөв	БОНХЯ
13.4	ЗГҮАХХУАТ 34, 226, Ус үндэсний хөтөлбөр 3.2	Ус, агаар, хөрсний чанарыг хянах шинжилгээний лабораторийн чадавхыг бэхжүүлж, орчны бохирдлын талаарх бодит мэдээллээр хангагдах	Шинжилгээний багажийн тоо	5	1.5 Улсын төсөв	БОНХЯ
13.5	ЗГҮАХХУАТ 243.4	Эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүч болон хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах "Ногоон барилга" санаачилгыг нэвтрүүлэх	Төслийн тоо	1	5 Улсын төсөв	БОНХЯ



<b>Зорилт 14. Гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.</b>						
14.1	ЗГҮАХХАХТ-ний 264.10 дахь заалт	Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	2.4 Улсын төсөв	Онцгой байдлын ерөнхий газар /цаашид ОБЕГ гэх/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /цаашид ЗГХЭГ гэх/, СЯ
14.2	ТХШТХ-ийн 9.3.6, ЗГҮАХХАХТ-ний 312.2, 281.2 дахь заалт	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх удирдлага, мэдээллийн системийг бий болгож, програм хангамж, техник хэрэгслийн хангалтыг сайжруулах	Мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажлын явц, хувь	100 хувьд	2.2 Улсын төсөв	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /цаашид МХЕГ гэх/
			Улсын байцаагчийн техник хэрэгслийн хангалт, хувь	80 хувь	1.2 Улсын төсөв	МХЕГ
<b>ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО</b>						
<b>Зорилт 15. Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, боловсролын тогтолцоог шинэчилнэ.</b>						
15.1	ЗГҮАХХАХТ-ний 194.1 дэх заалт	Боловсролын байгууллагын олон улсын багш солилцооны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдах багшийн тоо	40	1.0 Улсын төсөв	БШУЯ



15.2	ЗГҮАХХУАГ-ний	Инженерийн боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлж олон улсын загварыг туршиж	Загвар турших сургуулийн тоо	1	1.0 Улсын төсөв	БШУЯ
15.3	201.1, 201.2, 201.3	Багш, инженерийн чиглэлийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	Хөнгөлөлт үзүүлэх оюутны тоо	2300	3.4 Улсын төсөв	БШУЯ
15.4	ЗГҮАХХУАГ-ний 204.1, 204.2	Өрсөлдөх чадвартай монгол хүнийг хөгжүүлэх зорилгоор дэлхийн шилдэг сургуулиудад бакалавр, магистр, докторын хөтөлбөрт оюутан сургах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх	Суралцуулах оюутны тоо	100	9.0 Улсын төсөв	БШУЯ
15.5.	ЗГҮАХХАХТ-ний 192.3 дахь заалт	Их, дээд сургуулиудыг түшиглэн "Цахим сургалтын үндэсний төв" байгуулах	Шинээр байгуулах цахим сургалтын төвийн тоо	1	-	БШУЯ
15.6.	ЗГҮАХХАХТ-ний 300.1 дэх заалт	"Монгол залуу хүн" Үндэсний хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх	Хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлын явц, хувь	100 хувь	1.0 Улсын төсөв	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /цаашид "ХАХНХЯ" гэх/, ЗЗХЯ



**Зорилт 16. Эрүүл мэндийн салбарт орчин үеийн техник, технологийг ашиглахыг дэмжинэ.**

16.1	ҮХЦБ-ын Стратегийн зорилт 2, ЗГҮАХХАХТ-ний 167.2 дахь заалт	Импортын эмийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах шинэчлэлийг хийх	Олон улсын итгэмжлэл авсан байгууллагын тоо	1	0.1 Улсын төсөв	ЭМЯ
16.2	ЗГҮАХХАХТ-ний 183.2 дахь заалт	Орчин үеийн эмийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж, уламжлалт эм, тангийн үйлдвэрлэлийг өргөтгөх	Уламжлалт эмийн бүртгэлд хамрагдах хувь	25 хуртлах хувь	0.04 Улсын төсөв	ЭМЯ
16.3	ЗГҮАХХАХТ-ний 164.1 дэх заалт	Мэс заслын тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх өндөр өртөг бүхий мэс заслын хэрэгсэл, протезийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг болох эрх зүйн орчныг бүрдүүлэх	Эрх зүйн орчин бүрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	15.0 Эрүүл мэндийн даатгалын сан	ЭМЯ
16.4	ЗГҮАХХАХТ-ний 165.1 дэх заалт	Эх орондоо чанартай оношилгоо эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлж, оношилгоо эмчилгээний чанарын стандартыг шинэчлэх	Шинээр боловсруулах стандарт, удирдамжийн тоо	10	0.01 Улсын төсөв	ЭМЯ



16.5	Нийгмийн халамжийн тухай хуулийн 21.1.2 дахь заалт, 21.3 дахь хэсэг	Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо	35 мянга гаруй хүн	0.4 Улсын төсөв	ЭМЯ
16.6	ЗГҮАХХАХТ-ний 185.2 дахь заалт	Хүн амын эрүүл мэндэд хотжилтын нөлөөлөх нөлөөг судлан "Хотжилт ба эрүүл мэнд" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Боловсруулж, хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо,	1	0.35 Улсын төсөв	ЭМЯ
<b>Зорилт 17. Соёл, урлаг, биеийн тамир, спортыг тогтвортой хөгжүүлэх бодлогыг баримтална.</b>						
17.1	ЗГҮАХХАХТ-ний 1.3 дахь заалт	Биеийн тамир, спорт, соёл, урлагийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт болон ивээн тэтгэсэн хөрөнгийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Эрх зүйн орчин бүрдсэн байна.	100 хувь	0.01 Улсын төсөв	ССАЖЯ

**Зорилт 18. Нийгмийн хамгааллын салбарт хийх шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлнэ.**

18.1	ЗГҮАХХАХТ-ний 150.2 дахь заалт	Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэх	Шинээр боловсруулах хуулийн тоо	1	-	ХАХНХЯ, СЯ, ЭЗХЯ, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид "НДҮЗ" гэх/
18.2	ЗГҮАХХАХТ-ний 153.1 дэх заалт	Зорилтот бүлэгт үзүүлэх нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	-	ХАХНХЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ
18.3	ЗГҮАХХАХТ-ний 154.2 дахь заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах, тэдний эцэг, эх, гэр бүлд зөвлөгөө өгөх, дэмжин туслах хөгжлийн төвүүдийг бух аймаг, дүүрэгт үе шатайгаар байгуулах	Жшиг хөгжлийн төвүүдийг байгуулах ажлын явц, хувь	100 хувь	-	ХАХНХЯ, ЭМЯ, БШУЯ, ХЗЯ



<b>Зорилт 19.Хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах, ядуурлыг бууруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>						
19.1	ҮХЦБ-ын 4, 1, 4.8, "Ажилтай, орлоготой Монгол хүн" Үндэсний хөтөлбөрийн 3.9 дэх заалт	Цагийн ажлын тогтолцоо, аутсорсинг зэрэг хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэрийг хөгжүүлэх	Шинээр батлах хөтөлбөр, төсөл, журмын тоо	1 багц	1.0 Улсын төсөв	ХЯ, Мэргэжлийн холбоод
19.2	ЗГҮАХХАХТ-ний 33 дахь заалт	Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих	Батлан даалтын сангаас баталгаа гаргуулах орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийн эзлэх хувь	30 хувь	10.0 ЗБДС	ХЯ,СЯ, ЭЗХЯ
19.3	"Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр"-ийн 1 дүгээр зорилт	Үйлдвэрлэлийн кластерт ажлын байр бий болгосон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Томоохон аж ахуйн нэгжүүдийг даган хөгжих жижиг бизнес эрхлэгчдийн тооны өсөлт, хувь	25 хувь	-	ХЯ, Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн сан /цаашид "ЖДҮХС" гэх/
19.4	"Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр"-ийн 2 дугаар зорилт	Жижиг, дунд үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөрлөл, бүлгийн зохион байгуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдан борлуулах механизмыг боловсронгуй болгох	Борлуулалтын нэмэгдэх хэмжээ, хувь	70 хүртэл хувь	0.5 Улсын төсөв	ХЯ, СЯ, УХААЯ, ЭЗХЯ



19.5	ЗГҮАХХАХТ-ний 196.3 дахь заалт	Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний шатлал болон тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх	Шинээр боловсруулах стандартын тоо	30 хүртэл стандарт	-	ХЯ
<b>ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО</b>						
<b>Зорилт 20. Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэл, нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргийг бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.</b>						
20.1	ЗГҮАХХАХТ-ний 285.2 дахь заалт	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх нэгдсэн тогтолцоог үе шаттайгаар бүрдүүлэх	Тогтолцоо бүрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	ХЗЯ
20.2	ЗГҮАХХАХТ-ний 309.1 дэх заалт	Шүүхийн захиргаа, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон стандарт, дүрэм, журмыг батлан мөрдүүлэх	Стандарт, дүрэм, журмыг батлан мөрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	ХЗЯ, ЕТГ, Шүүхийн Ерөнхий зөвлөл /цаашид "ШЕЗ" гэх/
20.3	ЗГҮАХХАХТ-ний 295.2, 295.4 дэх заалт	Эрх зүйн бакалаврын стандартад өөрчлөлт оруулж, мөрдүүлэх	Стандартыг өөрчилж, мөрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	ХЗЯ
20.4						



20.5	ЗГУАХХАХТ-ний 291.2, 291.3 дахь заалт	Гэрч, хохирогчид тусалцаа үзүүлэх, тэднийг хамгаалах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулах, зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	14.0 Улсын төсөв	ХЗЯ
20.6	ЗГУАХХАХТ-ний 273.1, 273.4 дэх заалт	“Архигүй Монгол хүн” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	ХЗЯ, УХААЯ, Ерөнхийлөгчийн Тамгын газар /цаашид “ЕТГ” гэх/
<b>Зорилт 21.Бүс нутаг дахь байр сууриа бэхжүүлэх бодлогыг баримтална.</b>						
21.1	УХЦБ-ын 7.5.1.8, ГБУБ-ын 2.14.3, 3.21.4, ЗГУАХХАХТ- ний 253.10 дахь заалт	Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)- д элсэх чиглэлээр идэвхтэй ажиллах	АПЕК-т манай улс гишүүнээр элсэхийг дэмжихээ албан ёсоор илэрхийлэх орны тоо	1-ээс дээш орон	1.5 Улсын төсөв	ГХЯ

21.2	<p>ҮХЦБ-ын 7.5.1.9, ГБУБ-ын 2.14.3, 3.21.4, ЗГҮАХХАХТ-ний 253.10 дахь заалт</p>	<p>Зүүн Азийн дээд түвшний уулзалтын манай улс гишүүнээр элсэхийг дэмжихээ албан ёсоор илэрхийлэх орны тоо</p>	<p>Зүүн Азийн дээд түвшний уулзалтад манай улс гишүүнээр элсэхийг дэмжихээ албан ёсоор илэрхийлэх орны тоо</p>	<p>1-ээс дээш орон</p>	<p>1.0 Улсын төсөв</p>	ГХЯ
21.3	<p>ЗХА-ийн асуудлаарх Улаанбаатар хотын яриа хэлэлцээ санаачилгын бусад улсад таниулах, дэмжлэг авах чиглэлээр ажиллах</p>	<p>ЗХА-ийн асуудлаарх Улаанбаатар хотын яриа хэлэлцээ санаачилгын бусад улсад таниулах, дэмжихээ илэрхийлсэн орны тоо</p>	<p>ЗХА-ийн асуудлаарх Улаанбаатар хотын яриа хэлэлцээ санаачилгын бусад улсад таниулах, дэмжихээ илэрхийлсэн орны тоо</p>	<p>1-ээс дээш орон</p>	<p>2.0 Улсын төсөв</p>	ГХЯ
<b>Зорилт 22. Олон улсын байгууллагын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.</b>						
22.1	<p>ҮХЦБ-ын 7.5.1.7, ГБУБ-ын 2.14.4, ЗГҮАХХАХТ-ний 254.1 дэх заалт</p>	<p>Олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр сууриа бэхжүүлэх</p>	<p>Байр сууриа илэрхийлэх байдал, давтамж</p>	<p>2-оос доошгүй удаа</p>	<p>2.1 Улсын төсөв</p>	ГХЯ
		<p>Манай улсын санаачлан батлуулах тогтоолын тоо</p>		<p>1-ээс дээш</p>		ГХЯ



22.2	<p>ҮХЦБ-ын 7.5.1.7, ГБУБ-ын 2.14.4, ЗГУАХХАХТ-ний 254.4 дэх заалт</p>	<p>НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүний 2022 оны сонгууль, Хүний эрхийн зөвлөлийн 2015 оны сонгуульд сонгогдох чиглэлээр ажиллах</p>	<p>Монгол Улс нэр дэвшиж, сонгогдох ажлын явц, хувь</p>	<p>100 хувь</p>	<p>5.0 Улсын төсөв</p>	ГХЯ
22.3	<p>ҮХЦБ-ын 7.5.1.7, ГБУБ-ын 2.14.4, ЗГУАХХАХТ-ний 254.1 дэх заалт</p>	<p>Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)- ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, байр сууриа бэхжүүлэх</p>	<p>ЕАБХАБ-ын үйл ажиллагаан дахь манай улсын оролцоо</p>	<p>2-оос багагүй удаа оролцсон байна.</p>	<p>1.1 Улсын төсөв</p>	ГХЯ
22.4	<p>ҮХЦБ-ын 7.5.1.1, ГБУБ-ын 1.4, 2.14.5, ЗГУАХХАХТ-ний 253.12 дэхь заалт</p>	<p>Монгол Улстай дипломат харилцаагүй, НҮБ-ын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох ажлыг идэвхтэй үргэлжлүүлэх</p>	<p>Дипломат харилцаа тогтоох орны тоо</p>	<p>2-оос доошгүй орон</p>	<p>0.2 Улсын төсөв</p>	ГХЯ



**Зорилт 23.Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаална.**

23.1	<p>ҮХЦБ-ын 7.5.3.1, ГБУБ-ын 6.27.5 ЗГҮАХХАХТ-ний 258.1 дэх заалт</p>	<p>Хилийн чанадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалж, "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"- ийн үйл ажиллагааг өргөжүүлэх</p>	<p>Сангийн үйл ажиллагаа өргөжсөн байна.</p>	-	<p>1.0 Улсын төсөв</p>	ГХЯ СЯ
23.2	<p>ГБУБ-ын 6.27.3, ЗГҮАХХАХТ-ний 258.2 дахь заалт</p>	<p>Гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх хүрээнд бусад улстай визгүй харилцан зорчих, визийн нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр ажиллах</p>	<p>Хөнгөвчлөх нөхцөлтэйгээр зорчих хэлэлцээр хийсэн орны тоо</p>	<p>2-оос доошгүй орон</p>	<p>0.8 Улсын төсөв</p>	ГХЯ
23.3	<p>ГБУБ-ын 2.14.5, 7.29.4, ЗГҮАХХАХТ-ний 256.1 дэх заалт</p>	<p>Монгол Улсын ардчилал, хүний эрх, зах зээлийн эдийн засгийн замнал, туршлагыг хөгжиж байгаа бусад улстай хуваалцах зорилгоор Олон улсын хамтын ажиллагааны сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх</p>	<p>Хөгжиж байгаа бусад улсад Узүүлсэн техникийн тусламжааны төслийн тоо</p>	<p>1-ээс дээш төсөл</p>	<p>3.5 Улсын төсөв</p>	ГХЯ



Зорилт 24.Батлан хамгаалах, хил хамгаалалт, иргэний хамгаалалтын салбарын чиглэлээр бодлого хэрэгжүүлнэ.						
24.1	ЗГҮАХХАХТ-ний 247.4 дэх заалт	Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	30.3 Улсын төсөв	ХЗЯ Хил хамгаалах ерөнхий газар /цаашид ХХЕГ гэх/
24.2	ЗГҮАХХАХТ-ний 247.2 дахь заалт	Хилийн асуудлаар хөрш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллах;	Үйл ажиллагааны хэрэгжилт	30 хувь	0.45 Улсын төсөв	ХЗЯ ХХЕГ
24.3	ЗГҮАХХАХТ-ний 244.7 дахь заалт	Цэргийн дайчилгааны бодлогод шинэчлэл хийж, дайчилгааны нөөц бүрэлдэхүүнийг сургах тогтолцоог боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	143.3 Улсын төсөв	Батлан хамгаалах яам /цаашид "БХЯ" гэх/, Зэвсэгт хүчний жанжин штаб /цаашид "ЗХХШ" гэх

24.4	ЗГҮАХХАХТ-ний 248.1 дэх заалт	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох хэлбэрийг өргөжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	20.7 Улсын төсөв	БХЯ ЗХХЖШ
24.5	ЗГҮАХХАХТ-ний 249.4 дэх заалт	Батлан хамгаалах салбарт ажиллах энгийн иргэн, боловсон хүчний бодлогыг шинэчлэн боловсруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	55.5 Улсын төсөв	БХЯ ЗХХЖШ
24.6	ЗГҮАХХАХТ-ний 251.5 дахь заалт	Ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх болон экологийн төрөл бүрийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд цэргийн хүчний оролцоог нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	24.0 Улсын төсөв	БХЯ ЗХХЖШ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

### Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 10-т заасан “Цагаан суварга”-ын ордод төр хувь эзэмших шаардлагагүй гэж үзсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin\_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 7.75

Индекс: 14003